

## **ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2021.12.01

Дархан-Уул аймаг

Тус хэлтэс нь 2021 онд **“Цахим үйлчилгээ бидний хэрэглээ”** зорилтыг дэвшүүлэн иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэл, бүртгэл хяналтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж, бүртгэлийн үйлчилгээг иргэдэд ил тод, түргэн шуурхай, чирэгдэлгүй, үнэн зөв, хүртээмжтэй хүргэж Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Архивын тухай хууль болон холбогдох бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг ханган дараах ажлуудыг хугацаанд хийж гүйцэтгэлээ.

### ***НЭГ. ДЭЭД ШАТНЫ БАЙГУУЛЛАГЫН ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН***

Тус хэлтэс нь дараах Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаал, албан бичгээр ирүүлсэн үүрэг даалгавар, зөвлөмж, чиглэлүүдийг бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд:

#### **УБЕГ-ын даргын тушаалын хэрэгжилт:**

1. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын “Эрхийн улсын бүртгэлийг хаах тухай” А/22, А/45, А/46, А/79, А/93, А/122, А/190, А/240, А/321, А/440, А/584, А/605, А/680, “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай” А/59, “Журам батлах тухай” 2021 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/102, “Нууц хамгаалах ажилтныг томилох тухай” 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/148, “Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд тэмдэг хэрэглэх журамд өөрчлөлт оруулах тухай” 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/170, А/171, “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай” 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/215, “Итгэмжлэгдсэн ажилтны орон тооны хязгаарыг батлах тухай” 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/239, “Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтны орон тооны хязгаарт өөрчлөлт оруулах тухай” 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/264, “Албан томилолтоор ажиллуулах тухай” 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/300, “Иргэний шилжилт хөдөлгөөнийг бүртгэлийг сэргээх тухай” 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/344, “улсын бүртгэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2021 оны 05 дугаар сарын 27 ны өдрийн А/304, “Журам, хэвлэмэл хуудас, эрх зүйн баримт бичгийн загвар тухай” 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн А/341, “Улсын бүртгэлийн лавлагааны маягт батлах тухай” 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/395, “Эд хөрөнгийн улсын бүртгэлийн үйл

ажиллагаанд хэрэглэх мэдүүлэг маягтын загварыг шинэчлэн батлах тухай” 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/429, ”Журамд өөрчлөлт оруулах тухай” 2021 оны 07 дүгээр сарын 08 ны өдрийн А/450, “Иргэний шилжилт хөдөлгөөний түр зогсоох тухай” 2021 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн А/471, А/742, А/743, “Улсын хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн батлах тухай” 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/705, А/706, А/707, “Тушаал хүчингүй болсон тооцох тухай” 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/724 дугаар тушаалуудын хэрэгжилтийг ханган ажилласан

2. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай” 2021 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн А/59, “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай” 2021 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн А/215 дугаар тушаалуудын хэрэгжилтийг ханган ажиллаж иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн санал авах өдрийг дуустал түр зогсоосон.

3. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн Б/22, 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн Б/25, 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн Б/45, 2021 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн Б/72, 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн Б/117, 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн Б/183, 2021 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн Б/212, Б/213, 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн Б/289, 2021 оны 09 дугаар сарын 14-ний өдрийн Б/406, Б/409, Б/410, Б/411, 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн Б/487, 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн Б/517, Б/519, 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн Б/562, 2021 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн Б/583, дугаар тушаалуудын хэрэгжилтийг тус тус ханган ажиллаж тухай бүр нь холбогдох албан хаагчдад танилцуулан зохих журмын дагуу ажлыг хүлээлэлцүүлж, холбогдох акт тэмдэглэлийг үйлдэж баталгаажуулан ажилласан.

### **Иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэл зөвлөмж:**

Тус тасаг нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаал, албан бичгээр ирүүлсэн үүрэг даалгавар, зөвлөмж, чиглэлүүдийг бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд:

### **УБЕГ-ын даргын тушаалын хэрэгжилт:**

1. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай” 2021 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн А/59, “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай” 2021 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн А/215 дугаар тушаалуудын хэрэгжилтийг ханган ажиллаж иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн санал авах өдрийг дуустал түр зогсоосон.

2. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулах зардлын төсөв батлах тухай” 2021 оны 3 дугаар сарын

18-ны өдрийн А/176, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны даргын хамтарсан “Журам батлах тухай” 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн А/213/38, “Итгэмжлэгдсэн ажилтны орон тооны хязгаарыг батлах тухай” 2021 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн А/239, “Улсын бүртгэлийн байгууллагын Итгэмжлэгдсэн ажилтны орон тооны хязгаарт өөрчлөлт оруулах тухай” 2021 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн А/264, “Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг сэргээх тухай” 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн А/344, “Улсын бүртгэлийн лавлагааны маягт батлах тухай” 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн А/395, “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай” 2021 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн А/471, А/472, дүгээр тушаалуудын хэрэгжилтийг ханган ажилласан.

### **Иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэл зөвлөмж:**

1. Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн 2/699 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн хэрэгжилтийг ханган дараах ажлуудыг хийж гүйцэтгэн тус аймгийн нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй сонгуулийн эрх бүхий иргэний тоог хуульд заасан хугацаанаас өмнө /[Election.gasr.mn/](http://Election.gasr.mn/) гаргаж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд 2021 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн 172 тоот албан бичгээр хүргүүлсэн.

- Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд эрх авсан улсын ахлах бүртгэгч, улсын бүртгэгч нар 4 сумын 39-н сонгуулийн хэсэгт хамаарах санал авах байр буюу хэсгийн төв түүнд хамаарах хаягийн мэдээллийг шивж баталгаажуулах ажлыг 2021 оны 03 дугаар сарын 01-ний дотор хийж гүйцэтгэсэн.

- “Сонгуулийн хэсэг байгуулж, нутаг дэвсгэрийг зарласан тухай” тогтоолуудын эх хувийг нэгтгэлийн хамт Иргэний улсын бүртгэлийн газарт 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 250, хуулбар хувийг Хяналт шалгалтын газарт цахимаар болон 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 249 тоот албан бичгээр хугацаанд нь тус тус хүргүүлсэн. Мөн Дархан, Орхон, Хонгор, Шарын гол сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолуудыг мэдээллийн санд PDF файл хэлбэрээр хугацаанд нь оруулж, хэлтэст хуулбар хувийг авч үлдсэн.

2. Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн 2/2330 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн хэрэгжилтийг ханган дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг 2021 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн ажлын цаг дуустал хүлээн авч Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 332 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам”-д заасны дагуу холбогдох эх нотлох баримт бичгийг үндэслэн бүртгэл хөтөлж хүсэлт гаргасан иргэний мэдээлэл болон холбогдох эх нотлох баримт бичгийг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд нягтлан шалгаж, тухай бүр нь бүртгэж, баталгаажуулсан.

- Сумдын улсын бүртгэгч нарын 2021 оны 4 дүгээр сарын 09-ний өдрөөс өмнө шилжилт хөдөлгөөний бүртгэл хөтөлсөн бүртгэсэн төлөвтэй байгаа иргэний мэдээллийг нягталж, алдаагүй, зөв, бүрэн гүйцэд баталгаажуулж дуусгасан.


- Шилжилт хөдөлгөөний бүртгэлийг тогтоосон хугацаанд зогсоон сумдын улсын бүртгэгч нар шилжилт хөдөлгөөний бүртгэлийн дэвтрүүдэд “шилжилт хөдөлгөөний бүртгэлийг түр зогсоосон” тухай тэмдэглэгээг хийж, бүртгэлийн дэвтэр болон ИУБ-22 маягтын үлдэгдлийг тулган нягталж, акт үйлдэн хэлтсийн даргын өрөөнд хадгалах ажлыг зохион байгуулсан.

3. Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 1/2722 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу сонгуулийн хэсгийн хорооны дэргэд ажиллах итгэмжлэгдсэн ажилтны судалгааг гаргаж Тамгын газрын Эрх зүйн хэлтсийн [/ts.oyunbileg@birtgel.gov.mn/](mailto:ts.oyunbileg@birtgel.gov.mn) цахим хаягт хугацаанд нь хүргүүлсэн.

4. Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 1/2694 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд заасны дагуу итгэмжлэгдсэн ажилтнаар төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийг сонгож ажиллуулахдаа орон нутгийн холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан.

- Ирүүлсэн загварын дагуу итгэмжлэгдсэн ажилтнуудтай гэрээг байгуулж, нууцын баталгаа гаргуулсан.

5. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хамтын ажиллагаа, сургалтын хэлтсээс цахимаар өгсөн чиглэл, УБЕГ-ын даргын баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу тус хэлтсийн итгэмжлэгдсэн ажилтнаар томилогдсон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн 7 дугаар тойргийн 40 хэсгийн хороонд ажиллах 43 итгэмжлэгдсэн ажилтанд эрхзүйн сургалтыг 2021 оны 5 дугаар сарын 11-ний өдөр цахимаар зохион байгуулан ажилласан.



6. Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 5/2985 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

-УБЕГ-ын даргын баталсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулиар Улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний

дагуу хэлтэст хэрэгжүүлэх ажлыг нэг бүрчлэн тодорхойлсон төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг тооцон ажилласан.

-“Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах журам”-ын 2.6.1 - 2.6.6-т заасан мэдээллийг цахим санд **үнэн зөв, бүрэн гүйцэд** оруулсныг нягтлан шалгах ажлыг тухай бүр нь хийж гүйцэтгэсэн.

- Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолд заасан сонгуулийн хэсэгт хамаарах нутаг дэвсгэрт байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгогчдын нэрийн жагсаалтад бүрэн бүртгэсэн эсэхийг тогтмол шалган ажилласан.

- [Burtgel.gov.mn](#) цахим хуудсанд байрлуулсан сонгогчдын нэрийн жагсаалтад мэдээлэл зөрүүтэй гэж мэдээлсэн иргэдийн мэдээллийг тухай бүр нь шалгаж, шийдвэрлэн холбогдох мэдээ, мэдээллийг хугацаанд нь [songuuli2021@burtgel.gov.mn](mailto:songuuli2021@burtgel.gov.mn), [l.unurtuya@burtgel.gov.mn](mailto:l.unurtuya@burtgel.gov.mn) цахим хаягуудаар хүргүүлсэн.

- [Burtgel.gov.mn](#) цахим хуудсанд байрлуулсан сонгогчдын нэрийн жагсаалт дахь сонгогчийн мэдээлэлд санал авах байрны хаяг, байршлын мэдээллийг нэмж тусгасан тул аймаг, сумдын сонгуулийн хороотойгоо мэдээлэл солилцон хамтран ажилласан.

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.6 дахь хэсэгт заасны дагуу холбогдох байгууллагаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн мөн хуулийн 19.7, 19.8 дахь хэсэгт заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалтад холбогдох тэмдэглэгээ хийгдсэнийг нягтлан шалгасан.

7. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газраас 2021 оны 5 дугаар сарын 04-ний өдөр ирүүлсэн сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх хуваарь, цахимаар өгсөн чиглэлүүдийн дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Сонгуулийн хэсэг оноогдоогүй сонгогчид хэсэг оноох ажлыг хийж гүйцэтгэн сонгогчдын нэрийн жагсаалтыг хэвлэх эрх хүссэн албан бичгийг 2021 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн **439 тоот албан бичгээр** хүргүүлэн эрх нээлгэсэн.

- Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх бэлтгэл ажлыг урьдчилан ханган, хэвлэх үйл ажиллагааг 2021 оны 5 дугаар сарын 13-ны өдөр хуваарийн дагуу тогтоосон хугацаанд хэлтсийн №4 тоот өрөөнд халдвар хамгааллын дэглэмийг сахиж, зохион байгуулалтын арга хэмжээг авч нийт 6 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр хийж гүйцэтгэсэн.



- Хэвлэх эрх авсан улсын бүртгэгч нар өөрсдийн эрхийн дагуу програмд нэвтэрч сонгогчдын нэрийн жагсаалтыг хэсэг тус бүрээр 2 хувь хэвлэх ажлыг 11:00 цагт эхлүүлэн 13:35 цагт дуусгасан.

- 2021 оны 5 дугаар сарын 13-ны өдөр сонгогчдын нэрийн жагсаалт хүлээлцсэн тухай акт, нууцын баталгааг тус бүр 2 хувь үйлдэн бэлэн болгосон.

8. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.9-т заасны дагуу болон Иргэний улсын бүртгэлийн газраас цахимаар өгсөн чиглэлийн дагуу сонгогчдын нэрийн жагсаалтыг хуваарийн дагуу хугацаанд нь хэвлэж тус хэлтэс нь сонгогчдын нэрийн жагсаалтыг хүргэх хуваарь гарган аймаг, сумдын сонгуулийн хороотой хамтран ажиллаж сонгогчдын нэрийн жагсаалтыг хуульд заасны дагуу тогтоосон хугацаанд сонгуулийн хороодод хүргэх ажлыг аймгийн Тагнуулын хэлтэстэй хамтран зохион байгуулсан.

2021.05.13	Сургалтын үндэсний байрлал	Сургалтын өдөр	Урьд	Хуваарийн өдөр	Хуваарийн үйл ажиллагаа
1	Дархан-Уул аймаг	2021.05.13	2021.05.13	2021.05.13	Хуваарийн үйл ажиллагаа
2	Шарын сум	2021.05.14	2021.05.14	2021.05.14	Хуваарийн үйл ажиллагаа
3	Сүхбаатар сум	2021.05.14	2021.05.14	2021.05.14	Хуваарийн үйл ажиллагаа
4	Хангай сум	2021.05.14	2021.05.14	2021.05.14	Хуваарийн үйл ажиллагаа



9. Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 1/3426 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу дараах ажлуудыг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Хэсгийн хороодод ажиллах улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудыг хэсгийн хороодын ажиллах цагийн хуваарийн дагуу ажиллуулж, холбогдох мэдээлэл, зөвлөмжөөр тогтмол ханган ажилласан.

- Сонгогчийн шилжих хүсэлтийг Иргэний хуулийн 64 дүгээр зүйлийн 64.2 дахь хэсэгт заасан шаардлага хангасан итгэмжлэл болон холбогдох нотлох баримтыг үндэслэн бүртгэсэн.

- Итгэмжлэгдсэн ажилтнуудаас хүлээн авсан сонгогчийн шилжих хүсэлт, маягтуудыг хяналтын улсын байцаагчаар хянуулан хянасан тэмдэглэгээ хийлгэж PDF хэлбэрээр программд оруулан “Сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай лавлагаа /Маягт-4”/-ийг хэвлэсэн.

- Сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай 655-н лавлагаа /Маягт-4/-г хэвлэсэн

10. Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн чиглэл хөтөлбөрийн дагуу сургалтын бэлтгэл ажлыг ханган тус хэлтсийн нийт албан хаагчид болон итгэмжлэгдсэн ажилтнаар томилогдсон сонгуулийн 40 хэсгийн хороонд ажиллах 43 итгэмжлэгдсэн ажилтнуудад сургалтыг 2021 оны 5 дугаар сарын 29-ний өдөр УБЕГ-ын “Сургалтын баг”-тай хамтран аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд зохион байгуулан ажилласан.



11. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газар, Бодлог төлөвлөлт, дүн шинжилгээний газраас цахимаар ирүүлсэн чиглэлийн дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн санал авах өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиар улсын бүртгэлийн байгууллагад хүлээлгэсэн чиг үүргийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах чиг үүргийн дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Санал авах өдөр гарсан асуудлыг Election.gazr.mn системийн “Сонгууль” цэсний “Сонгуулийн өдөр” гэсэн талбарт тухай бүрт нь бүртгэсэн. Зөврийн битүүмжилсэн хайрцгаар санал өгсөн сонгогчийн бүртгэлийг хийх үед 3-н хэсгийн хороонд тус бүр 1, 1 асуудал үүссэн. Эдгээр асуудал нь тухайн хэсгийн хороодын ажлын хариуцлагагүй байдлаас үүссэн байсан тул тухай бүр нь аймаг, сумын сонгуулийн хороонд мэдэгдэж хэсгийн хороо тус бүрт нь протокол үйлдүүлэн асуудлыг шийдвэрлүүлсэн.

- Хэсэг тус бүрээс болон иргэдээс утсаар ирүүлсэн нийт 119-н дуудлагыг хүлээн авч тухайн сонгогчийн байнга оршин суугаа хаяг болон санал өгөх хэсгийн төвийг хэлж өгч мэдээлэл өгч ажилласан. /Тухайн дуудлагууд нь иргэд өөрсдийн мэдээллээ хуулийн хугацаандаа шалгаагүй, шалгах боломжгүй, санал авах байраа хаана байрладаг зэргийг мэдэхгүй зэрэг шалтгаантай байсан/

- Ирц бүртгэлийн мэдээг 11:00, 15:00, 22:00 цагт итгэмжлэгдсэн ажилтнуудаас авч нэгтгэн БТДШГ-т хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

-Аймгийн Тагнуулын хэлтэс дээр цагдаагийн албан хаагчдийн хамгаалалттайгаар итгэмжлэгдсэн ажилтнуудыг хэсгийн хороодоос ирүүлж итгэмжлэгдсэн ажилтан тус бүрээс тоног төхөөрөмж, сонгогчдын нэрийн жагсаалт, үйлдсэн тэмдэглэл болон сонгогчдын бүртгэлийн хуудсыг акт үйлдэн хүлээх авах ажиллагааг 2021 оны 6 дугаар сарын 09-ний өдрийн 23:30 цагаас 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 13:20 цаг хүртэл зохион байгуулан ажиллаж хүлээн авсан.

12. Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 2/4607 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу МУ-ын Засгийн газрын 2020 оны 230 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээ”-г 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөн иргэний улсын бүртгэлийн лавлагааг энгийн цаасан дээр хэвлэж, улсын бүртгэгч хувийн дугаар бүхий дардас, гарын үсгээр баталгаажуулан

ажиллаж байна. Лавлагаа олгоход ашиглаж байсан А-4, А-5 үнэт цаасны үлдэгдлийг улсын бүртгэгч нар зарцуулалтын тайлангийн хамт гаргаж 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдөр хэлтсийн ахлах нягтлан бодогч, нярав нартай тооцоо нийлэн буцаан өгсөн.

13. Иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн аймгийн хэмжээн дэх хаягийн мэдээлэл судалгаа ирүүлэх албан бичгийн дагуу 4 сумын хаягийн бүртгэлийн талаарх саналыг цаг хугацаанд нь хүргүүлсэн.

14. Тайлангийн хугацаанд бичгээр ирүүлсэн, цахимаар өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр нь хийж гүйцэтгэн хугацаанд нь тайлагнан ажилласан.

### **Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэл:**

#### ***1.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 7/1707 дугаарын чиглэлийн хүрээнд:***

- Чиглэлийг хэлтсийн дарга тасгийн бүртгэгч нар болон хяналтын улсын байцаагчид танилцуулан хэрэгжилтийг ханган ажиллах, тодорхой ажлыг зохион байгуулахыг үүрэг болгосон.

- Хувийн хэргийг мэдээллийн сантай тулгаж тоолон зөрчлийг арилгах ажлыг жилийн төлөвлөгөөнд төлөвлөн ажиллаж тайлант хугацаанд 5000 хувийн хэргийг тоолж, тооллогын явцад цахимжаагүй 72 хувийн хэргийн судалгааг гаргаж холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

- Газар эзэмших “Э”, ашиглах “А” эрх бүртгүүлсэн судалгаа, мэдээ тайланг хугацаанд нь буюу сар бүрийн 25-ны өдөр [edkhusus@burtgel.gov.mn](mailto:edkhusus@burtgel.gov.mn) хаягаар хүргүүлэн ажилласан.

- Газар эзэмших, ашиглах эрхтэй холбоотой 1579-н мэдээллийг хэвлэн авсан бөгөөд архивын хууль тогтоомжийн дагуу хугацаанд нь хадгаламжийн нэгж үүсгэн ажилласан.

- Эрхийн улсын бүртгэлд бүртгэхэд эргэлзээтэй улсын бүртгэлийн Y-200318160 дугаарт бүртгэлтэй бүртгэлийг хэрхэн хөтлөх талаар чиглэл авах тухай хүсэлтийг хүргүүлж холбогдох хариуг ЭХЭУБГ-аас авсан.

- Цахим мэдээллийн санд цахимжуулалтын болон бусад алдаа байгаа эсэхийг тухай бүр шалгаж хяналтын улсын байцаагчид залруулах дүгнэлт гаргуулахаар шилжүүлэн ажиллаж нийт 57-н бүртгэлийн алдааг залруулан ажилласан.

#### ***2.УБЕГ-ын даргын 2021 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 1/2215 дугаарын чиглэлийн хүрээнд:***

- Тайлант хугацаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд тусгай тэмдэглэл хийх, хүчингүй болгуулахаар нийт 217-н албан бичгийг хөрөнгийн эрхийг түдгэлзүүлэх тогтоолын хамт ирүүлсэн.

- Шүүхийн шийдвэрээр хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг түдгэлзүүлсэн бүртгэлтэй байхад уг шүүхийн шийдвэрийг үндэслэн дахин түдгэлзүүлэх 1 шийдвэр



ирүүлсэн тул шийдвэр гүйцэтгэх байгууллагад албан бичгээр мэдэгдэж тогтоолыг буцаасан бөгөөд чиглэлийн бусад хэрэгжилтийг ханган ажилласан болно.

### **3.УБЕГ-ын даргын 2021 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 8/2228 дугаарын чиглэлийн хүрээнд:**

- Хяналт шалгалтын газраас гүйцэтгэлийн шалгалтыг цахимаар хийхтэй холбогдуулан эх нотлох баримтыг цахимжуулах, төлөвлөгөөт шалгалтаар илэрсэн бүртгэлийн алдаа зөрчлийг арилгасан нотлох баримт, бүртгэлийн дэвтрийг PDF файл үүсгэн бэлтгэл ажлыг 100 хангаж ажилласан.

### **4.ЭХЭУБ газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 7/2734 дугаарын чиглэлийн хүрээнд:**

- Нотариатын мэдээлэл шалгах системээр дамжуулан хийгдэх бүртгэл тайлант хугацаанд бүртгэгдээгүй бөгөөд холбогдох бүртгэл хийхэд анхаарч ажиллахыг улсын бүртгэгч нарт танилцуулсан болно.

- Хяналтын улсын байцаагчийн 53-н дүгнэлтээр 57-н бүртгэлд засвар өөрчлөлт хийж мэдээллийн санд өөрчлөлтийг 100 хувь оруулсан.

- Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Ажлын байрыг дэмжих 3 хувийн хүүтэй зээл олгогдож эхэлсэнтэй холбоотойгоор арилжааны банкууд бүх салбар нэгжүүдээрээ дамжуулан эрх шилжих, лавлагаа, ипотекийн гэрээ болон өмнө бүртгүүлсэн гэрээний нэмэлт өөрчлөлтийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх иргэн, хуулийн этгээдийн хүсэлт огцом нэмэгдэж Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдал болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт ажиллаж буй онцгой нөхцөл байдлын хугацаанд иргэдийн бөөгнөрөл үүсгэх, халдвар хамгааллын дэглэм зөрчигдөх, короновируст халдвар тархах өндөр эрсдэлийг үүсгэж болзошгүй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх, иргэн, хуулийн этгээдийн банктай байгуулсан барьцааны гэрээнүүдийг банкнаас нэгтгэн ирүүлэх, банкны ажилтан мэдүүлгийн хуудсыг бөглүүлж улсын бүртгэгчид шилжүүлэх зорилгоор 2021 оны 04 сарын 02-ны өдрийн албан тоотыг банк болон банк бус санхүүгийн байгууллагууд хүргүүлэн холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас тусгай тэмдэглэл бүртгэх, хүчингүй болгох, сэргээхэд мэдээллийг бүрэн гүйцэд тодорхой тусгасан эсэхийг нягтлан шалгаж, эрх түдгэлзүүлэх тухай тогтоол, албан бичгийг үндэслэн бүртгэлийг хөтөлж хэвшсэн.

- Бүртгэл хөтлөхдөө эрхийн улсын бүртгэлийн цахим систем /ePRS/-д мэдээллийг үнэн зөв оруулах, бүртгэлийн төрөл, нэршлийг зөв сонгон оруулахад анхааран ажиллаж байна.

- Хэлтсийн болон эд хөрөнгийн тасгийн хурлаар Хэлтсийн дарга дүрэм журмыг мөрдөж, бусдын нөлөөнд автахгүй, ашиг сонирхлоос ангид байхыг удаа дараа анхааруулан ажиллаж байгаа бөгөөд тасгийн бүртгэгч нараас ашиг сонирхолд өртөхгүй байх тухай амлалтыг гаргуулан авсан болно.

**5. 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 27 дугаарын хяналтын улсын байцаагчийн “Зөрчил арилгуулах тухай” улсын байцаагчийн шаардлагын хүрээнд:**

- Эрхийн улсын бүртгэлийн Y-2003010882, Y-2003008587 дугаартай бүртгэлийн худалдах худалдан авах гэрээний үнийг өөрчлөөгүй цахимд санд бүртгэсэн, Y-2003016477, Y-2003023187 дугаартай бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг оруулаагүй зөрчилд хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг гаргуулж, “ePRS” цахим мэдээллийн санд зөрчлийг бүрэн арилган, зөрчил арилгасан талаарх илтгэх хуудсыг Хяналт шалгалтын газарт хугацаанд нь хүргүүллээ.

**6. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2021 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 6/4908 дугаар чиглэлийн хүрээнд:**

- 2021 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн А/429 дүгээр тушаалаар батлагдсан мэдүүлэг, маягтыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 230 дугаар тогтоолоор шинэчлэн тогтоосон Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд 2021 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн мөрдөн ажиллаж, яаралтай үйлчилгээний хөлс авахгүй, яаралтай үйлчилгээ үзүүлэхгүй болсон тул мэдүүлэг хүлээн авсан дарааллаар хууль заасан хугацааны дотор ажлын ачаалалдаа тохируулан эрхийн улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

**7. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2021 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 6/4939 дугаарын чиглэлийн хүрээнд:**

- Эрхийн улсын бүртгэлд засвар өөрчлөлт оруулахдаа хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн өөрчлөлтийг оруулж хэвшсэн бөгөөд тайлант хугацаанд 152 засвар өөрчлөлтийн бүртгэл хийсэн.

**8. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 06-ний өдрийн А/429 тоот “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэглэх мэдүүлэг, маягтын загварыг шинэчлэн батлах тухай” тушаалын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд:**

- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэглэх холбогдох маягтуудыг холбогдох журмын дагуу үйл ажиллагаандаа хэрэглэж мэдүүлэг хүлээн авах улсын бүртгэгч нарт шаардлагатай хурууны хээ уншигчийг ашиглан мэдээллийн сангаас шинээр батлагдсан ЭУБ-01 маягтыг иргэний хурууны хээ уншуулж мэдүүлгийг хэвлэн ажиллаж байна.

**9. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн 6/6841 дугаарын чиглэлийн хүрээнд:**

2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн газрын дугаар олгох системээс дугаар олгоогүй, автоматаар дугаар олгогдсон газар эзэмших, ашиглах эрхтэй холбоотой мэдээллийн 209 хуудсыг уг системээс хэвлэн авч дугаарын дарааллын дагуу архивт хүлээлгэн өгсөн.

### **Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэл:**

1. УБЕГ-ын 2021.03.29-ны өдрийн 1/2215 тоот чиглэлийн дагуу Хуулийн этгээдийн бүртгэлд хориг тавих тусгай тэмдэглэл хийх, сэргээх чиглэлийг үндэслэн 1 хуулийн этгээдийн хоригийг сэргээж бүртгэл хөтлөн ажилласан.

2. УБЕГ-ын 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 6/2938 тоот чиглэлийг үндэслэн Хуулийн этгээдийн зарим үйл ажиллагааны чиглэлийг Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал, ангиллын тодорхойлолтод нийцүүлэн бүртгэл хөтлөн ажиллаж байна.

3. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн дугаар 125 тоот тогтоолоор “Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангаас лавлагаа, мэдээлэл өгөх журам”-ыг үндэслэн мэдээлэл, лавлагааг хуулийн хүрээнд олгон ажиллаж байна.

### **Хяналт шалгалтын газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэл:**

УБЕГ-ын Хяналт шалгалтын газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 8/1364 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэл, УБЕГ-ын даргын баталсан “Шилжилт хөдөлгөөний бүртгэлд хяналт шалгалт хийх” удирдамж, 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 2/2330 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэл, “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай” УБЕГ-ын даргын 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/215 дугаар тушаал, Хяналт шалгалтын газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 8/2473 тоот албан бичиг, УБЕГ-ын даргын 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 1/3426 тоот албан бичгээр тус тус ирүүлсэн чиглэлийн хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэж хэрэгжилтийг хангуулан тайланг хугацаанд нь хүргүүлсэн.

### **Бусад чиглэл, зөвлөмж:**

1. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газраас 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 9/117 тоот албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж биелэлтийг 2021 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 425 тоот албан бичгээр хугацаанд нь хүргүүлсэн.

2. Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 11/622 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу хэлтсийн ББНШК хуралдаж хадгалах хугацаа нь дууссан устгах баримт бичгийн актыг хэлэлцэж баталсан.

3. Цахим хаягаар ирүүлсэн “Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн боловсруулж буй төсөлтэй танилцаж саналаа хугацаанд нь 2021.01.28-ны өдөр цахим хаягаар хүргүүлсэн.

4. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газрын 2021 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 3/1111 тоот албан бичгээр ирүүлсэн уриалгыг улсын бүртгэгч нарт танилцуулах хуудсаар танилцуулан хэрэгжүүлж ажиллахыг анхааруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.


5. Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 7/1304 тоот албан бичгээр ирүүлсэн үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажилласан.

6. Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 1/2215 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу хуулийн этгээдийн бүртгэлд хориг тавих тусгай тэмдэглэл хийж, 1 хуулийн этгээдийн хоригийг сэргээх бүртгэл хөтөлсөн.

### **ХОЁР. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:**


1. Тайлант хугацаанд иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлийн мэдээлэл нь огт тусгагдаагүй болон мэдээлэл нь дутуу, алдаатай тусгагдсан бүртгэлийг бүртгэлийн дэвтэр, холбогдох маягт, мэдээлэл удирдах систем болон хувийн хэргээс шалгаж илрүүлсэн **337-н** бүртгэлийн зөрчлийг ИУБГ-т тухай бүр нь албан бичгээр хүргүүлэн ажиллаж зөрчлийг **100 хувь** арилгуулсан.

2. Цахим үнэмлэх огт аваагүй 20, 16 нас хүрсэн **1576-н** иргэнийг иргэний шинэчилсэн бүртгэлд хамруулж иргэний цахим үнэмлэхжүүлсэн. Анх удаа болон, 25, 45 насны сунгалт, хаяж үрэгдүүлэн дахин авах хүсэлт гаргасан **2489** нийт **5502** иргэний цахим үнэмлэхний мэдээллийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд тусгаж, баталгаажуулан үнэмлэхжүүлсэн.



3. **1329-н** иргэнд үндэсний энгийн гадаад паспорт, **4421-н** иргэнд сум, баг хоорондын хаягийн хөдөлгөөн, **2023-н** иргэнийг шилжин ирсний бүртгэлийг хөтөлсөн байна.

Тайлант хугацаанд олгосон үндэсний энгийн Е серийн гадаад паспортын бүртгэлийг графикаар харуулбал:




Нийт хүсэлт гаргасан 1329-н иргэний материалыг хүлээн авч Иргэний улсын бүртгэлийн газарт тухай бүр нь албан бичгээр хүргүүлэн ажилласан.

4. Сумдаас ирүүлсэн болон хэлтсийн иргэний улсын бүртгэлийн 14010-н ИУБ маягтыг нягтлан шалгаж цахим санд шивж, баталгаажуулан журмын дагуу холбогдох тоон мэдээ, тайланг 14 хоног, сар, улирлаар гарган хугацаанд нь УБЕГ-ын ИУБГ-т хүргүүлж байгаа бөгөөд сар бүр ИУБ маягтуудын “А” талыг ИУБГ, УБНАГ-т шилжүүлэн ажилласан.

5. Шүүхийн шийдвэр болон хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр 12 иргэний регистрийн дугаарыг өөрчилж ИУБ маягтыг холбогдох журмын дагуу хийн ИУБГ-т хүргүүлэн цахим санд өөрчлөлтийг тусгуулан холбогдох бичиг баримтыг сольж олгосон.

6. Тайлангийн хугацаанд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр нийт 20229-н бүртгэл хийсэн бөгөөд үүнийг графикаар үзүүлбэл:



7. Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд тодорхой төрлийн бүртгэлийг харьяалал харгалзахгүй бүртгэхээр өөрчлөлт орсон тул тус хэлтсээс бүртгэлийн үйлчилгээ авч байгаа иргэдийн тоо нэмэгдэж, бүртгэлийн тоо өссөн байна.

### **ГУРАВ. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Тайлант хугацаанд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр иргэн, хуулийн этгээдээс нийт 16784-н мэдүүлгийг хүлээн авч улсын бүртгэлд бүртгэсэн Үүнд:

#### **1. Эд хөрөнгө өмчлөх эрхийг анх удаа бүртгэж баталгаажуулах-1046**

- Төрөөс үнэ төлбөргүй хувьчилсан орон сууцны өмчлөх эрхийн бүртгэл 60

- Төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийн анхны баталгаажуулалт 139
  - Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг бүртгэсэн баталгаажуулалт 269
  - Шинээр баригдсан орон сууц анх удаа бүртгэж баталгаажуулсан 431
  - Өмчлөгчийн хүсэлтээр болон гэрээ хэлцлээр бүртгэл салгаснаар шинэ бүртгэл үүсэх 146
2. **Өмчлөх эрх шилжих нийт бүртгэгдсэн 3259 гэрээнээс:**
- Худалдах худалдах авах гэрээ 2449
  - Бэлэглэлийн гэрээ 264
  - Арилжааны гэрээ 11
  - Өв залгамжлал, гэрээслэлээр өмчлөгч өөрчлөгдөх 95
  - Хамтранөмчлөгч өөрчлөгдөх 249
  - Өмчлөгчийн үүсгэн байгуулсан ХЭ-ээс иргэнд, иргэнээс үүсгэн байгуулсан ХЭ-ийн өмчлөлд өмчлөх эрх шилжих 3
  - Эд хөрөнгийн үнэ өмчлөгчийн овог нэр өөрчлөгдөх 3
  - Шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх 13
  - Албадан дуудлага худалдаагаар өмчлөгч өөрчлөгдөх 3
3. **Барьцааны гэрээ нийт 11028 бүртгэгдсэнээс**
- Барьцаалбаргүй барьцааны гэрээ 2860
  - Барьцаалбартай барьцааны гэрээ 2868
  - Барьцаалбаргүй барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах 101
  - Барьцаалбартай барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах 265
  - Барьцааны гэрээ дуусгавар болох 4934
4. **Бусад гэрээ нийт 4 бүртгэгдсэнээс**
- Түрээсийн гэрээ 4
5. **Бүртгэлд өөрчлөлт оруулах бүртгэл нийт 690 бүртгэгдсэнээс**
- Эд хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөх 131
  - Эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх 178
  - Эд хөрөнгийн зориулалт өөрчлөгдөх 5
  - Эд хөрөнгийн үнэ өмчлөгчийн овог нэр , регистр өөрчлөгдөх 25
  - Өмчлөгчийн хүсэлтээр бүртгэл салснаар хэмжээ өөрчлөгдөх 195
  - Газрын нэгж талбарын дугаар өөрчлөгдөх 101
  - Гэмтээсэн гэрчилгээ шинээр олгох 8
  - Үрэгдүүлсэн гэрчилгээ шинээр олгох 47
6. **Лавлагаа мэдээлэл нийт 331 бүртгэгдсэнээс**
- Лавлагаан авах /эдхөрөнгө/ 270
  - Хуулбар хийлгэх 45
  - Хувийн хэрэг хаах 16
7. **Урьдчилсан тэмдэглэл 24 бүртгэгдсэнээс:**
- Урьдчилсан тэмдэглэл хүчингүй болгох 19
  - Урьдчилсан тэмдэглэл хийх 15

Нийт 16784-н бүртгэл хөтлөн үйлчилгээний хураамж болох 247,317.920 төгрөгийг улсын төсөвт, үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсан татварын орлого 2,010.478.269 төгрөг, тэмдэгтийн хураамж 8,536.405 төгрөг нийт **2,266.332.594** улс, орон нутгийн төсвийн дансанд төвлөрүүлсэн байна.

2018, 2019, 2020, 2021 онуудын боловсруулалт хийгдсэн мэдүүлгийн тоо хүлээн авсан тоог графикаар харьцуулбал:



#### 8. Газар эзэмших ашиглах эрхийн бүртгэлийн талаар:

Дундын мэдээллийн санд нийт 1579-н эзэмших эрхийг улсын бүртгэлд бүртгэж Э дугаар олгосон. Үүнд:

- Дархан сум- 665
- Орхон сум -205
- Хонгор сум- 683
- Шарын гол сум -26 тус тус бүртгэгдсэн байна.

#### ***ДӨРӨВ. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:***

1. Тайлант хугацаанд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр дараах бүртгэлийг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Шинээр бүртгэгдсэн аж ахуйн нэгж -198
- Үүсгэн байгуулах баримт бичигт нэмэлт өөрчлөлт орсон -393
- Хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт хийсэн -199
- Татан буугдаж улсын бүртгэлээс хасагдсан хуулийн этгээд -17
- Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар бүртгүүлэх -9


- Дахин гэрчилгээ -54
- Тамга, тэмдгийн хяналтын дугаар олголт -253
- Хуулийн этгээдийн хураан авсан тамга тэмдэг -72
- Өргөдөл, лавлагаа – 115
- Ирсэн, явуулсан албан бичиг - 44
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой хуулбар – 107

2. Нийт **870-н** материалыг хүлээн авч бүртгэл хөтлөн улсын бүртгэлийн бүртгэлийн тэмдэгтийн хураамж **17,089.000** мянган төгрөгийг улсын төсөвт, үйлчилгээний хураамж **2,868.500** төгрөгийг тус тус төвлөрүүлэн ажиллалаа.

3. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 12 зүйлийн 12.5 дах хэсэгт зааснаар тусгайлан эрх олгосон байгууллагын эрх бүхий албан тушаалтны хүсэлтийн дагуу 44-н лавлагаа, мэдээллийг олгож нийт **107-н** хуудас хуулбар олгосон.

4. Бүртгэлийг хуулийн хугацаанд хийж “ERS” программд тухай бүр оруулж мэдээллийг тогтмол шинэчилж архивт хувийн хэргийг хугацаан нь хүлээлгэн өгч ажилласан.

- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийг сүүлийн 3 оноор харьцуулбал:




### **ТАВ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Улсын бүртгэлийн багц хуулиуд болон бусад дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавихдаа Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны А/341 дүгээр тушаалаар баталсан “Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам”-ыг баримтлан чиг үүргийн дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:



### 1. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хяналт шалгалт, бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр:

Улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой иргэн, хуулийн этгээдээс 99 өргөдөл, гомдол, улсын бүртгэгч нараас 157 хүсэлт, нийт 256 өргөдөл хүсэлтийг хүлээн авч, нотлох баримт дутуу, дүгнэлтээр шийдвэрлэх шаардлагагүй 10 өргөдлийг буцаан холбогдох эзэнд нь хариу мэдэгдсэн, 21 өргөдөл, хүсэлтийн хугацаа болоогүй, 225 өргөдөл, хүсэлтийн дагуу иргэний улсын бүртгэлээр 110, хуулийн этгээдийн улсын бүртгэлээр 1, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлээр 170, нийт 281 дүгнэлт үйлдэж бүртгэлийн алдаа, зөрчлийг шийдвэрлэн ажилласан байна.



Тайлант хугацаанд бүртгэлийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалтыг 1 удаа, төлөвлөгөөт бус шалгалтыг 2 удаа хийж гүйцэтгэлээ. Төлөвлөгөөт бус шалгалтаар УБЕГ-ын дарга, Улсын ерөнхий байцаагчийн 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн “Улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь хэлтсээс иргэний үнэмлэх, гадаад паспорт, улсын бүртгэлийн гэрчилгээг барьцаалж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх удирдамж”-ийн дагуу Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг иргэн, хуулийн этгээдэд танилцуулах, хуулийн заалтыг хэрэгжүүлэн ажиллах тухай мэдэгдлийг тус аймагт иргэдийн бичиг баримтыг үндэслэн үйлчилгээ үзүүлдэг банк болон банк бус байгууллага, үүрэн телефоны байгууллагын салбар 16 байгууллагад хүргүүлэн, 100 аж ахуйн нэгжийг хяналт шалгалтад хамруулан, гүйцэтгэлийн тайланг хугацаанд нь хүргүүлсэн.






Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын баталсан Дархан-Уул, Сэлэнгэ аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд хийх гүйцэтгэлийн шалгалтын удирдамжийн дагуу тус аймагт 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрөөс 04 дүгээр сарын 30-ны өдрүүдэд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар хяналтын улсын байцаагч Н.Анхбаярын ирүүлсэн 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 27 дугаартай албан шаардлагыг хүлээн авч хяналтын улсын байцаагчийн 2929 дугаарын дүгнэлтээр иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд бүртгэлийн мэдээллийг залруулах, 3195, 3196, 3252, 3253 дугаарын дүгнэлтээр эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээлэлд нэмэлт, засвар өөрчлөлт оруулахаар тус тус шийдвэрлэн холбогдох зөрчлийг арилгуулан ажиллалаа. Нийт илэрсэн 27 зөрчлөөс 5 зөрчлийг дүгнэлтээр шийдвэрлэж, 22 зөрчлийн талаар холбогдох улсын бүртгэгч нараас тайлбарыг, тасгийн дарга нараас илэрсэн зөрчлийг хэрхэн шийдвэрлэсэн талаар илтгэх хуудсыг тус тус гаргуулан авч тайлангийн хамт хугацаанд нь хүргүүлсэн.

Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд иргэн, хуулийн этгээдээс гаргасан 56 гомдол мэдээллийг хүлээн авч шийдвэрлэн 53 хүнд 1 220 000 /нэг сая хоёр зуун хорин мянган/ төгрөгөөр торгох шийтгэл оногдуулж хялбаршуулсан журмаар шийдвэрлэн, 1 гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзан, 2 гомдлыг Өршөөл үзүүлэх тухай хуулийн дагуу хэрэгсэхгүй болгон шийдвэрлэж прокурорт хугацаанд нь хянуулан ажилласан.

Бүртгэлийн хууль тогтоомжийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг сурталчлах мэдээлэх зорилгоор Танд тусалъя брошур мэдээллийг бэлтгэж, 9 удаа нийт 700 ширхгийг хэвлэн үйлчилгээний танхим, самбарт байршуулах, хэлтсээс зохион байгуулсан Нээлттэй хаалганы өдөр арга хэмжээний



Дархан-Уул аймаг дахь улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны үйл ажиллагааны тайлан



2. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд УБЕГ-ын дарга, Хяналт шалгалтын газрын даргаас ирүүлсэн тушаал шийдвэр, хяналт шалгалт хийх удирдамж, албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэн хугацаанд нь тайлагнасан. Үүнд:

1. Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс 04 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэл хугацаанд Дархан суманд бүртгэсэн 1593, Орхон суманд 53, Хонгор суманд 87, Шарын гол суманд 70, нийт аймгийн хэмжээнд 1803 бүртгэл хөтөлснийг 03 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн хяналтын улсын байцаагч нар хамтран шалгаж бүртгэлийн нотлох баримтын бүрдэл, агуулга хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, мэдээллийн санд үнэн зөв бүртгэл хөтөлсөн

эсэх, нотлох баримтыг бүрэн гүйцэд цахимжуулсан эсэхийг хянаж шалгахын зэрэгцээ улсын бүртгэгч нарт байнгын мэдээлэл зөвлөгөө өгч, удирдамжийн дагуу хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэн 7 хоног бүр илтгэх хуудсаар тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлэн ажилласан.


2. Хяналт шалгалтын явцад илэрсэн 7 зөрчлийг хяналтын улсын байцаагчийн 1220 дугаартай дүгнэлтээр зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч, зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг мөрдөж ажиллахыг анхааруулан хяналтын улсын байцаагчийн 01 тоот мэдэгдлийг иргэний улсын бүртгэлийн тасагт хүргүүлэн ажиллалаа.

3. Чиглэлийн дагуу шилжилт хөдөлгөөний бүртгэлийг түр зогсоон сумдын улсын бүртгэгч нараас бүртгэлийн дэвтрүүд, үлдэгдэл ИУБ-22 маягтуудыг хүлээн авч акт үйлдэн лацдах үйл ажиллагаанд хяналт тавин ажилласан.

4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахаар УБЕГ-ын даргын 2021 оны 05 сарын 13-ны өдрийн 1/3426 тоо албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу сонгогч шилжих үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж шилжин явсан, ирсэн нийт 614 бүртгэлийг хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хянаж, сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах 655 лавлагааг хуулийн дагуу үнэн зөв хэвлэсэн эсэхэд хяналт тавьж ажиллалаа.

5. Иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагаанд байнгын болон түүвэрчилсэн хяналтаар 6047 бүртгэлд хяналт тавьж, 30 зөрчил илэрснийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр шийдвэрлэн зөрчлийг арилгуулсан.

6. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр нийт 110 дүгнэлт үйлдэж, иргэний улсын бүртгэлтэй холбоотой тодорхой нөхцөл байдлуудыг тогтоон иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, улсын бүртгэгч нараас ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэн ажиллалаа. Үүнд:



1. Иргэний үнэмлэхийн бүртгэлд тавих хяналтыг сайжруулан улсын бүртгэгч нарын бүртгэл хөтлөлтийг тогтмол хянаж, иргэний үнэмлэхээ хаяж үрэгдүүлсэн, хүчинтэй байдлыг алдагдуулсан, овог, эцэг /эх/-ийн нэр, нэр, регистрийн дугаар өөрчлөгдсөн, хаяг өөрчлөгдсөн үндэслэлээр иргэний үнэмлэхээ солиулах хүсэлт гаргасан 1339 иргэний эзэмшиж байсан иргэний үнэмлэхийг хүчингүй болгохоор 66 дүгнэлт гарган Иргэний улсын бүртгэл хөтлөх журмын 8.6, 8.8 дахь заалтын хэрэгжилтийг хангуулж үйл ажиллагааг хэвшүүлэхэд анхаарч ажиллалаа. Эдгээр 1339 иргэний 33 иргэн нь 25, 45 нас хүрч иргэний үнэмлэхээ солиулахаар биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд бүртгүүлэхгүйгээр иргэний үнэмлэхээ гээгдүүлсэн үндэслэлээр дахин авсан зөрчил илэрснийг 8 удаагийн дүгнэлтээр шийдвэрлэн биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд хамруулж, цаашид улсын бүртгэгч нарт бүртгэлийн мэдээллийг нягтлан шалгаж илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллахыг чиглэл болгон хяналт тавьж ажилласан.

2. Иргэний регистрийн дугаар сэргээх 4, регистрийн дугаар хүчингүй болгох 1, регистрийн дугаар өөрчилж олгох 8, төрсний бүртгэл, гэрлэсний бүртгэл, овог нэр өөрчилсний бүртгэлийн мэдээлэлд засвар өөрчлөлт хийх 12, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл хүчингүй болгох 5, засвар өөрчлөлт хийх 9, гэрлэсний бүртгэлийг мэдээллийн санд оруулах 2, төрсний бүртгэлийг мэдээллийн санд оруулах 2, нийт 43 дүгнэлт үйлдсэн байна. Үүнээс улсын бүртгэгч нарын гаргасан алдаа зөрчил илэрснийг залруулах, мэдээллийн санд засвар өөрчлөлт оруулахаар 5 дүгнэлт гарган шийдвэрлэж ажиллалаа.


ИУБТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд 3 иргэнээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хүлээн авч Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.4-т заасныг баримтлан холбогдох иргэнд сонсох ажиллагаа явуулан 1 иргэний хаягийн бүртгэлийг түдгэлзүүлэх дүгнэлт гарган шийдвэрлэж, 1 өргөдлийн дагуу холбогдох 5 иргэний хаягийн зөрчлийг арилгуулан, 1 өргөдлийн дагуу хяналт шалгалт хийж авсан арга хэмжээг өргөдөл гаргагчид мэдэгдэж шийдвэрлэсэн.

### **3. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр:**

Тайлангийн хугацаанд 509 бүртгэлд байнгын болон түүвэрчилсэн хяналт тавьж, хяналт шалгалтын явцад илэрсэн 20 зөрчлийг арилгахаар дүгнэлт үйлдэж шийдвэрлэн ажиллалаа.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлээр нийт 170 дүгнэлт үйлдэж иргэн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, гомдол, улсын бүртгэгч нараас гаргасан хүсэлтийг шийдвэрлэн ажилласан. Үүнд:

эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр үйлдсэн дүгнэлтийн нийт дүн -170



1. Иргэн Б.Хашинчулуун /ТЖ83072011/-ын гаргасан хүсэлтийн дагуу газар өмчлөх эрхийн улсын бүртгэлийг нэгтгэх, хэд хэдэн улсын бүртгэлийн дугаарт бүртгэгдсэн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн зөрчлийг арилгуулах хүсэлт гаргасан Кредит Монгол ББСБ-ын албан бичгийн дагуу холбогдох бүртгэлийн үйл ажиллагааг шалгаж Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-т заасныг үндэслэн эрхийн улсын бүртгэлийг хаах тухай хяналтын улсын байцаагчийн 2 дүгнэлт үйлдэж өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн.

2. Иргэн Ш.Мухтар /ШЖ65122871/, Ч.Лхүндэв /ЧО62121773/ нараас ирүүлсэн өргөдлийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Y-2003020217, Y-2003014213 дугаарт, иргэн Ц.Сосор /ТЯ56121124/-ын гаргасан өргөдлийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Y-2001000759, Y-2001000631 дугаарт, улсын бүртгэгч Н.Шүрхүүгийн ирүүлсэн хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Y-2003010521, Y-2003011237 дугаарт, иргэн Б.Балжидмаа /ПЮ68031605/-ын гаргасан өргөдлийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Y-2003015770, Y-2003016431 дугаарт тус тус бүртгэл давхардсан зөрчлийг шалган тогтоож Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5-д заасныг үндэслэн эрхийн улсын бүртгэлийг хүчингүй болгох тухай 4 дүгнэлт үйлдэж, зөрчлийг арилгахаар шийдвэрлэсэн.

3. Аймаг, сумын ИТХ, аймгийн Засаг даргын захирамжаар Дархан сумын 15 дугаар багийн Мангирт 8 дугаар хэсгийн нутаг дэвсгэрийн харьяаллыг Хонгор суманд шилжүүлэхээр шийдвэрлэсний дагуу иргэнээс гаргасан 1 өргөдөл, улсын бүртгэгчээс ирүүлсэн 3 хүсэлтийн дагуу 4 дүгнэлт үйлдэж, 41 үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн дугаарыг хүчингүйд тооцох шийдвэр гаргасан.

4. “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргийг мэдээллийн санд тулгаж тоолох тухай” хэлтсийн даргын 2020 оны А/02 дугаар, 2021 оны А/03 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах хүрээнд хувийн хэргийн цахимжуулах явцад гаргасан алдаа зөрчлийг арилгуулахаар улсын бүртгэгч нараас ирүүлсэн 27

хүсэлтийн дагуу 35 дүгнэлтээр 336 үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулахаар шийдвэрлэн ажилласан.

5. Бүртгэлийн үйл ажиллагааны явцад цахим мэдээллийн санд алдаатай, буруу, дутуу цахимжуулсан зөрчил илэрснийг арилгуулахаар улсын бүртгэгчийн гаргасан 44 хүсэлт, иргэн, хуулийн этгээдээс гаргасан 16, нийт 60 өргөдөл хүсэлтийн дагуу 60 дүгнэлт үйлдэж 65 үл хөдлөх эд хөрөнгө болон газар өмчлөх эрхийн бүртгэлийн мэдээлэлд нэмэлт, засвар өөрчлөлт хийхээр шийдвэрлэн ажиллалаа.

6. Цахим мэдээллийн сан шинэчлэгдсэнтэй холбогдон эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг цахим мэдээллийн санд оруулсан байх боловч мэдээллийн зураг харагдахгүй алдаа гарсныг арилгуулахаар улсын бүртгэгчээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 53 улсын бүртгэлийн дугаартай үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээг дахин цахимжуулж мэдээллийн санд засвар өөрчлөлт оруулахаар 1 дүгнэлт үйлдэж алдаа зөрчлийг арилгуулсан.

7. Эрхийн улсын бүртгэлийн Y-2003006145 дугаарт бүртгэлтэй үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч өмчлөх эрхээ шилжүүлэхээр мэдүүлэг гаргасны дагуу бүртгэлийг хянаад хүчингүй болгосон гэрчилгээгээр бүртгэл хөтөлсөн, өмчлөх эрхээ шилжүүлэхээр мэдүүлэг гаргасан зөрчлийг илрүүлэн улсын бүртгэгчээс ирүүлсэн хүсэлтийн дагуу акт үйлдэж зөрчилтэй гэрчилгээг хураан авч, дүгнэлт үйлдэж зөрчлийг арилгуулсан.

8. Улсын бүртгэгч нарын алдаатай буруу бүртгэсэн 16 зөрчлийг арилгуулахаар 14 дүгнэлт үйлдэж бүртгэлийн мэдээллийг залруулсан байна.

9. УБЕГ-ын даргын 2020 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн А/1172 дугаар тушаалаар эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хаяж, үрэгдүүлсэн иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу гэрчилгээг хүчингүйд тооцсон дүгнэлт гаргаж шийдвэрлэх эрхийг шилжүүлсний дагуу 65 дүгнэлтээр 66 үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээг хүчингүйд тооцож дүгнэлтийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасагт шилжүүлэн биелэлтэд хяналт тавьж ажилласан.

Тус хэлтэс хариуцагчаар татагдаж хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа дараах хэрэг маргаанд:

1. Эрхийн улсын бүртгэлийн Y-2003012070, Г-2003002158 дугаарт холбогдох бүртгэл хүчингүй болгуулах тухай иргэн О.Ууганбаярын нэхэмжлэлтэй иргэний хэрэг;

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-2003021861, Y-2003021862 дугаарт Ласти Интернэшнл ХХК-иас иргэн Д.Болормаагийн өмчлөлд шилжүүлэн бүртгэсэн өмчлөх эрхийн бүртгэлийг хүчингүй болгуулах тухай тус орон сууцны өмчлөгч 7 иргэний нэхэмжлэлтэй захиргааны хэрэг;

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-2003018160 дугаарт өмчлөх эрхийг бүртгэхээс татгалзсан шийдвэрийг хүчингүй болгуулах тухай иргэн Ч.Жамьянсүрэнгийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг;

4. Эрхийн улсын бүртгэлийн Y-2003021861, Y-2003021862 дугаарт бүртгэлтэй Д.Болормаагийн өмчлөх эрхийн бүртгэлийг хүчингүйд тооцуулах тухай иргэн Э.Мөнхтуяагийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг;



5. Эрхийн улсын бүртгэлийн Y-2003021861, Y-2003021862 дугаарт бүртгэлтэй Д.Болормаагийн өмчлөх эрхийн бүртгэлийг хүчингүйд тооцуулах тухай иргэн П.Төрмөнхийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг;

6. Эрхийн улсын бүртгэлийн Y-2003018431 дугаарт бүртгэлтэй үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч О.Баярсайхантай байгуулсан барьцааны гэрээ эрхийн улсын бүртгэлд бүртгэгдээгүйг бүртгэлд тусгуулах тухай иргэн Р.Даваагийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэгт хяналтын улсын байцаагч, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн ахлах бүртгэгч нар байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр тус тус оролцож, О.Ууганбаярын нэхэмжлэлтэй хэрэг маргаан эцэслэн шийдвэрлэгдсэн, 4 хэрэг маргаан эцэслэн шийдвэрлэгдээгүй байна.

#### 4. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд байнгын болон түүвэрчилсэн хяналтаар 119 бүртгэлийг хянаж, төлөвлөгөөт шалгалт хийх удирдамжийг хэлтсийн даргаар батлуулан 358 бүртгэлийг түүвэрлэн шалгаж, 9 бүртгэлийн нотлох баримтыг цахим мэдээллийн санд бүртгээгүй, бүртгэл хөтлөхдөө нотлох баримтад тэмдэг буруу дардаг, хувийн хэрэг, нотлох баримт, хураалгасан тамга тэмдгийг журмын дагуу батлагдсан загвараар хугацаанд нь шилжүүлэн өгдөггүй, тамга тэмдгийн бүртгэлийг улсын бүртгэгч хөтөлдөггүй, хяналтын дугаар олгосон тамга тэмдэг хураалгасан, лавлагаа олгосон тухай баримт бичгийг архивын нэгж болгон архивт хүлээлгэж өгөөгүй зэрэг 5 зөрчлийг илрүүлэн хяналтын улсын байцаагчийн 01 тоот албан шаардлага өгч биелэлтийг хангуулан ажиллалаа. Хяналт шалгалтаар илэрсэн алдаа зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх, шинэчлэн батлагдсан журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож хэвшүүлэхийг үүрэг болгосон.

УБЕГ-ын хяналт шалгалтаар илэрсэн 27 алдаа зөрчлийг арилгуулахаар ирүүлсэн хяналтын улсын байцаагчийн албан шаардлагын дагуу хуулийн этгээдийн улсын бүртгэлд холбогдох 20 зөрчлийн бүртгэлийг хянаж улсын бүртгэгчийн гаргасан тайлбар, илтгэх хуудсыг хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулсан бүртгэлийн мэдээлэлд хувьцаа эзэмшигчийн мэдээлэл буруу, дутуу тусгагдсан тухай “Дархан зам”ХХК /РД:4258258/-ийн үүсгэн байгуулагч Т.Алтанцэцэгийн гаргасан өргөдлийн дагуу Хяналтын улсын байцаагчийн 179 дугаартай дүгнэлт үйлдэж холбогдох мэдээллийг залруулсан.

#### 5. Архивын чиглэлээр :

Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийн дагуу 243 хувийн хэргийн мэдээллийг шалгаж эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэгт нотлох баримтыг буруу байршуулсан 3, цахим санд бүртгэл хөтөлсөн боловч нотлох баримтыг архивт шилжүүлж өгөөгүй 1, хоёр хувийн хэргийн нотлох баримтыг хооронд нь сольж цахимжуулсан, нотлох баримтыг хувийн хэрэгт байршуулаагүй 1, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивт тамга, тэмдэг үйлдвэрлэх этгээдээс ирүүлсэн тайланг

хадгаламжийн нэгж болгон үдэж цэгцлээгүй, тамга тэмдэг устгасан тайланг баталгаажуулаагүй, үдэж цэгцлээгүй зэрэг 6 зөрчил илэрснийг арилгуулах арга хэмжээ авч, 5 зөрчлийг арилгуулсан, 1 зөрчил шийдвэрлэх шатандаа байна.

### **ЗУРГАА. УЛСЫН БҮРТГЭЛИЙН АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР:**


#### 1. Иргэний улсын бүртгэлийн архив:

Иргэний бүртгэлийн чиглэлээр мэдээлэл удирдах систем болон архивын цаасан эх нотлох баримтыг үндэслэн 9260-н иргэнд, эрх бүхий байгууллагад 1541-н лавлагаа олгосон.


Архивт хадгалагдаж буй иргэний баримтын архивын хувийн хэргийг төрсний, нас барсны, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд хамрагдсан, хамрагдаагүй, иргэний үнэмлэх огт аваагүй, харьяатаас гарсан иргэдийн хувийн хэргээр нь ангилан галиглан тус тусад нь сан үүсгэн хадгалж байна.

Иргэний баримтын архивын хадгаламжийн нэгж болох иргэний хувийн хэргийн тоон мэдээг улирал, жилээр тогтмол гарган хэвшсэн бөгөөд тус архивт 142,494 хадгаламжийн нэгж /хувийн хэрэг/ хадгалагдаж байна.


#### 1. Лавлагаа олголтыг сараар харуулбал:



#### 2. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр олгосон лавлагааг өнгөрсөн онуудын мөн үетэй харьцуулбал:



3. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны А/520 дугаар тушаалаар батлагдсан “Иргэний улсын бүртгэлийн баримт хүлээн авсан бүртгэл”, “Архиваас түр ашиглуулахаар олгосон иргэний баримтын бүртгэл”-ийн дэвтрүүдийг иргэний баримтын архивын үйл ажиллагаанд хэрэглэж хэвшүүлэн ажиллаж байна.



Д/д	ИУБ маягт нэр	Тус дэвтр	Иргэний баримтын олохон	Баримт өгөгдөл зөвхөн	Хувиар өөрчлөх үйл ажиллагаа	Хувиар өөрчлөх үйл ажиллагаа	Хувиар өөрчлөх үйл ажиллагаа	Хувиар өөрчлөх үйл ажиллагаа	Хувиар өөрчлөх үйл ажиллагаа	Хувиар өөрчлөх үйл ажиллагаа
1	1028-51	4	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51
2	1028-51	4	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51
3	1028-51	1	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51
4	1028-51	5	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51
5	1028-51	5	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51
6	1028-51	4	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51
7	1028-51	5	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51
8	1028-51	4	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51
9	1028-51	2	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51
10	1028-51	5	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51
11	1028-51	4	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51
12	1028-51	3	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51
13	1028-51	2	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51
14	1028-51	2	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51
15	1028-51	3	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51
16	1028-51	9	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51
17	1028-51	3	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51
18	1028-51	5	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51
19	1028-51	2	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51
20	1028-51	3	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51
21	1028-51	3	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51	1028-51

Иргэний баримтын архивын хувийн хэргийн тоо бүртгэл нь байнгын хөдөлгөөнтэй байдаг тул “Excel” програм дээр архивын сан хөмрөгийг нөхөн бүрдүүлэх үндсэн эх үүсвэрийн жагсаалт /ИУБ маягт тус бүрээр/, хувийн хэргийн тоо бүртгэлийг хөтлөн өөрчлөлт хөдөлгөөний талаар тухай бүр тэмдэглэлийг хийн ажиллаж байна.

Д/д	Саяагч нэр	1-сар	2-сар	3-сар	4-сар	5-сар	6-сар	7-сар	8-сар	9-сар	10-сар	11-сар	12-сар	Нийт
1	Саяагч	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	1200
2	Саяагч	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	1200
3	Саяагч	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	1200
4	Саяагч	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	1200
Нийт		400	400	400	400	400	400	400	400	400	400	400	400	4800

Д/д	Хайгуулагч нэр	Эхний сар	Төгсгөлийн сар	Хувийн хэргийн тоо	Урьдчилсан үнэ	Бүртгэлт иргэдийн тоо
1	Алтан Цэцэг	1	12	200	500	200
2	Батбаяр Чингал	1	12	150	700	150
3	Батбаяр Чингал	1	12	200	800	200
4	Алтан Цэцэг	1	12	210	810	210
5	Батбаяр Чингал	1	12	110	610	110
6	Алтан Цэцэг	1	12	100	710	100
7	Батбаяр Чингал	1	12	210	910	210
8	Алтан Цэцэг	1	12	180	780	180
9	Батбаяр Чингал	1	12	250	820	250
10	Алтан Цэцэг	1	12	190	760	190
11	Батбаяр Чингал	1	12	190	800	190
12	Алтан Цэцэг	1	12	190	880	190
13	Батбаяр Чингал	1	12	210	930	210

Д/д	Саяагч нэр	1-сар	2-сар	3-сар	4-сар	5-сар	6-сар	7-сар	8-сар	9-сар	10-сар	11-сар	12-сар	Нийт
1	Саяагч	30	31	31	30	30	30	30	30	30	30	30	30	360
2	Саяагч	1	2	1	1	1	1	1	1	1	1	1	1	12
3	Саяагч	1	2	1	1	2	2	1	1	1	1	1	1	15
4	Саяагч	1	3	6	3	4	2	1	3	4	1	1	1	28
Нийт		33	41	41	34	42	46	46	43	43	43	43	43	515

4. Тайлангийн хугацаанд улсын бүртгэгч нараас хүлээн авсан бүртгэлийн ИУБ маягт болон өөр аймаг, нийслэлээс ирүүлсэн нийт 930-н иргэний хувийн хэргийг тухай бүр нь холбогдох сангуудад 100 хувь байршуулсан.

5. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр олгосон лавлагаа, хадгаламжийн нэгжийн сарын тоон мэдээг тухай бүр хугацаанд нь гаргаж [t.baigalmaa@burtgel.gov.mn](mailto:t.baigalmaa@burtgel.gov.mn) цахим хаягаар хүргүүлэн ажилласан.

2. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын чиглэлээр:

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэг болон эх нотлох цаасан суурьтай баримт бичиг түүний хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангахын тулд Архив,албан хэрэг хөтлөлтийн тухай

хууль, Төрийн архивын үйл ажиллагааны нийтлэг журам, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 10-р зүйл болон бусад холбогдох эрх зүйн акт журмын дагуу мөрдлөг болгон ажиллаж байна.

1. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт нийт **45997** хувийн хэрэг буюу эх нотлох баримт хадгалагдаж байна. Үүнээс:

- Дархан Үл хөдлөх эд хөрөнгийн хувийн хэргийн тоо -23861
- Дархан Газрын хувийн хэрэг тоо -9698
- Хонгор сумын үл хөдлөх эд хөрөнгийн хувийн хэргийн тоо -911
- Хонгор сумын газрын хувийн хэргийн тоо-1017
- Орхон сумын үл хөдлөх эд хөрөнгийн хувийн хэргийн тоо-645
- Орхон сумын газрын хувийн хэргийн тоо-2461
- Шарын гол сумын үл хөдлөх эд хөрөнгийн хувийн тоо-1528
- Шарын гол сумын газрын хувийн хэргийн тоо-840
- Эзэмших-4983
- Ашиглах – 53

2. Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн улсын бүртгэлийг жилийн эцсийн байдлаар анхны бүртгэлийн баримт бичгийг архивт шилжүүлсэн тоон мэдээ

д/д	Хувийн хэргийн дугаар	Он, сар	Архивт шилжүүлсэн анхны бүртгэлийн хувийн хэргийн тоо	Хуудасны тоо
1	Ү2003023074-Ү2003023861 /100%дансжуулсан/	2021.01.05 2021.11.25	787	15740
2	Г2003009623-Г2003009698	2021.01.05 2021.11.25	75	1500
3	ШҮ2001001492- ШҮ2001001528	2021.01.05 2021.11.25	36	720
4	ШГ200100829- ШГ200100840	2021.01.05 2021.11.25	11	220
5	ХОҮ500886- ХОҮ500911	2021.01.05 2021.11.25	25	500
6	ХОГ500975- ХОГ5001017 /100%дансжуулсан /	2021.01.05 2021.11.25	42	840
7	ОГ4002390-ОГ2461	2021.01.05 2021.11.25	71	1420
8	ОҮ4000629- ОҮ4000645	2021.01.05 2021.11.25	16	320
9	Э-дугаар бүртгэл		458	458

- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн анхны бүртгэл -864
- Газар өмчлөх эрхийн улсын бүртгэлийн анхны бүртгэл- 199
- Эзэмших-458

Нийт: 1521-н анхны бүртгэл 21718-н хуудас архивын хувийн хэргийг / Маягт-6 Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргийг архивт хүлээн авсан бүртгэл/-ийн дэвтэрт бүртгэл хөтлөн Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2021 оны 07 сарын 08-ний өдрийн А/450 тоот тушаалын хэрэгжилтийг ханган “архивт хүлээн авав” тэмдгийн баримтын эхний хуудсанд голлуулан дарж, тэмдэглэгээ хийн архивын сан хөмрөгт байршуулсан.

3. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн эх нотлох баримтыг архивт хүлээн авч ангилан ялгаж хувийн хэрэгт байршуулав.

- Үл хөдлөх-11292 боловсруулагдсан материал
- Газар 4023 боловсруулагдсан материал

Нийт: 15315-н боловсруулагдсан материалыг хувийн хэрэгт байршуулан архивын сан хөмрөгт баяжуулах үйл ажиллагаа хийгдсэн байна.

4. Захиалгын хуудсаар захиалсан хувийн хэрэг


- Ахлах бүртгэгч, бүртгэгч, Хяналтын улсын байцаагч нарт захиалгын хуудсаар олгосон хувийн хэрэг-481
- Архиваас түр олгох баримтын бүртгэлийн дэвтэрт-434

Нийт 915-н хувийн хэргийг захиалгын дагуу гаргаж, хуулийн хугацаанд нь буцаан байршуулсан.

5. Эх баримтын 137-н хайрцаг савыг сэргээн засаж шинэчилсэн.

6. Архивын сан хөмрөгт хувийн хэргээр дугаараар нь заагч заагуурыг хийсэн.

7. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны А/520 дугаар тушаалаар батлагдсан Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн “Архиваас түр олгох баримтын баримтын бүртгэлийн дэвтэр”-ийг архивын үйл ажиллагаанд хэрэглэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.



№	Хувийн эрхийн бүртгэлийн дэвтэр	Анхны бүртгэл	Ой, сар, өдөр	Хувийн эрхийн хуудсын тоо	Архивын хөтөлгөөний нэр	Төлөө	Архивын түр олгох баримтын дэвтэр
1	4-1052	Амгис	2020.06.18	108	Дархан-Уул аймаг	1	Архиваас түр олгох баримтын дэвтэр
2	4-940	Амгис	2020.06.18	1	Дархан-Уул аймаг	1	Архиваас түр олгох баримтын дэвтэр
3	4-405	Маягт	2020.06.18	1-108	Дархан-Уул аймаг	1	Архиваас түр олгох баримтын дэвтэр
4	4-57	Амгис	2020.06.18	1-56	Дархан-Уул аймаг	1	Архиваас түр олгох баримтын дэвтэр
5	4-58	Амгис	2020.06.18	1-51	Дархан-Уул аймаг	1	Архиваас түр олгох баримтын дэвтэр
6	4-09	Амгис	2020.06.18	1-79	Дархан-Уул аймаг	1	Архиваас түр олгох баримтын дэвтэр
7	4-15	Амгис	2020.06.18	1-42	Дархан-Уул аймаг	1	Архиваас түр олгох баримтын дэвтэр
8	4-21	Амгис	2020.06.18	1-92	Дархан-Уул аймаг	1	Архиваас түр олгох баримтын дэвтэр
9	4-1052	Амгис	2020.06.18	1-108	Дархан-Уул аймаг	1	Архиваас түр олгох баримтын дэвтэр
10	4-1052	Амгис	2020.06.18	1-108	Дархан-Уул аймаг	1	Архиваас түр олгох баримтын дэвтэр
11	4-1052	Амгис	2020.06.18	1-108	Дархан-Уул аймаг	1	Архиваас түр олгох баримтын дэвтэр
12	4-1052	Амгис	2020.06.18	1-108	Дархан-Уул аймаг	1	Архиваас түр олгох баримтын дэвтэр
13	4-1052	Амгис	2020.06.18	1-108	Дархан-Уул аймаг	1	Архиваас түр олгох баримтын дэвтэр
14	4-1052	Амгис	2020.06.18	1-108	Дархан-Уул аймаг	1	Архиваас түр олгох баримтын дэвтэр
15	4-1052	Амгис	2020.06.18	1-108	Дархан-Уул аймаг	1	Архиваас түр олгох баримтын дэвтэр
16	4-1052	Амгис	2020.06.18	1-108	Дархан-Уул аймаг	1	Архиваас түр олгох баримтын дэвтэр
17	4-1052	Амгис	2020.06.18	1-108	Дархан-Уул аймаг	1	Архиваас түр олгох баримтын дэвтэр
18	4-1052	Амгис	2020.06.18	1-108	Дархан-Уул аймаг	1	Архиваас түр олгох баримтын дэвтэр
19	4-1052	Амгис	2020.06.18	1-108	Дархан-Уул аймаг	1	Архиваас түр олгох баримтын дэвтэр
20	4-1052	Амгис	2020.06.18	1-108	Дархан-Уул аймаг	1	Архиваас түр олгох баримтын дэвтэр
21	4-1052	Амгис	2020.06.18	1-108	Дархан-Уул аймаг	1	Архиваас түр олгох баримтын дэвтэр
22	4-1052	Амгис	2020.06.18	1-108	Дархан-Уул аймаг	1	Архиваас түр олгох баримтын дэвтэр
23	4-1052	Амгис	2020.06.18	1-108	Дархан-Уул аймаг	1	Архиваас түр олгох баримтын дэвтэр
24	4-1052	Амгис	2020.06.18	1-108	Дархан-Уул аймаг	1	Архиваас түр олгох баримтын дэвтэр
25	4-1052	Амгис	2020.06.18	1-108	Дархан-Уул аймаг	1	Архиваас түр олгох баримтын дэвтэр

8. Архивын сарын тоон мэдээг сар бүр хугацаанд нь [g.khuchitbaatar@burtgel.gov.mn](mailto:g.khuchitbaatar@burtgel.gov.mn) цахим хаягаар хүргүүлэн ажилласан.

3. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын чиглэлээр:

Хуулийн этгээдийн архивт шинэчилсэн бүртгэлд хамрагдсан -4151, Улаанбаатар хотоос шилжин ирсэн шинэчилсэн бүртгэлд хамрагдсан -57, УБ хотоос шилжин ирсэн шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй -183, Дархан-Уул аймагт

шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 60, нийт 4373-н хувийн хэрэг хадгалагдаж байна. Тайлангийн хугацаанд 222 анхны бүртгэлийн хувийн хэрэг нэмэгдсэн байна.

1. Хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн “Тамга, тэмдэг устгах ажлын хэсэг томилох тухай” 2021 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн А/06 дугаарын тушаалаар томилогдсон бүрэлдэхүүн 1, 2 дугаар улиралд 64-н аж ахуйн нэгжийн 64-н тамга, тэмдэг устгах ажлыг зохион байгуулан ажилласан.



2. Хэлтсийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хуулийн этгээдийн архивын хувийн хэргийг тоолох тооллогын ажлыг зохион байгуулан илтгэх хуудсаар хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагчид танилцуулсан.



3. Архивт хадгалагдаж байгаа хуулийн этгээдийн хувийн хэргийн эх баримтын 258-н хавтсыг сэлбэн засаж, сэргээн шинэчилсэн.

4. Хуулийн этгээдийн архивын сарын тоон мэдээг сар бүр хугацаанд нь [g.khuchitbaatar@burtgel.gov.mn](mailto:g.khuchitbaatar@burtgel.gov.mn) цахим хаягаар хүргүүлсэн.

Хэлтсийн хэмжээнд батлагдсан орон тоогоор 2 архивч ажиллаж байгаа бөгөөд 1 архивч нь байгууллагын болон эд хөрөнгийн архивыг, 1 архивч нь иргэний болон хуулийн этгээдийн архивыг тус тус хариуцан ажиллаж байна.

### ДОЛОО. БАЙГУУЛЛАГЫН АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР:

2021 онд байгууллагын архивын чиглэлээр хийгдэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа.

1. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23-р зүйлд заасны дагуу байгууллагын архивын үйл ажиллагаанд үүссэн баримт бичгийг бүрдүүлж, архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалтад заасан хугацаагаар 2020 оны хөтлөгдөж дууссан архивын баримт бичгийг архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, БНШКомиссын дүрэм журмын дагуу мөрдлөг болгон шалгаж, нийт 20 албан хаагчаас 344 боть, 16 дэвтрийг байгууллагын архивын ажлын нийтлэг журмын дагуу /хавсралт 6/ архивт хүлээн авсан баримтын бүртгэлийн дагуу бүртгэл үйлдэн Байгууллагын архивын сан хөмрөгт шилжүүлсэн байна.

БАТЛАВ  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮЙЛЧИЙГ ТУР БОЛОН  
ГҮЙЦЭТГЭЛТ ХУВИЦАГАА  
2021 оны 02 сарын 10 өдөр

БАРИМТ БИЧИГ НЯГТЛАН ШАЛГАХ КОМИССЫН  
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ 2021 ОНД ХИЙГДЭХ

2021 оны 02 дугаар сарын 10 ны өдөр үйлдэв

Д/д	Хийж гүйцэтгэх ажил	Хугацаа	Дархан-Уул Хариуцах эзэн
1	2020 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулах /Эн тасгаар гаргах/	2021.02.10	Э Бурмаа
2	2020 онд хөтлөгдөж дууссан баримт бичгүүдийг /албан хаагчдаас/ хадгаламжийн нэгж үүсгүүлэн архивт хүлээн авах /Захиргаа аж ахуй, Эд хөрөнгийн тасгаг/	2021.02.17	Д Долгоржав А Болорммаа
3	2020 онд хөтлөгдөж дууссан баримт бичгүүдийг /албан хаагчдаас/ хадгаламжийн нэгж үүсгүүлэн архивт хүлээн авах / иргэний бүртгэлийн тасгаг/	2021.02.18 2021.02.19	Д Долгоржав А Болорммаа Э Бурмаа Д Гантула
4	Албан хаагчаас архивт хүлээн авсан 2020 оны хадгаламжийн нэгжид бүртгэл үйлдэх	2021.02.22	Д Долгоржав
5	Баримт бичиг хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалт, Байгууллагын баримт бичиг хадгалах хугацааны жагсаалт зэргийг үндэслэн байгууллагын архивын хадгалах хугацаа дууссан баримт бичигт устгах хэргийн актыг жагсаалтаар гаргах	2021.03.05	Д Долгоржав
6	Хадгалах хугацаа дууссан устгах хэргийн актыг БНШКомиссын хурлаар хэлэлцэж хэлтсийн даргаар батлуулах	2021.03.09	ББНШКомисс
7	2020 онд хөтлөгдөж дууссан баримтуудыг байгууллагын архивт шилжүүлэх, тус бүртгэл үйлдэн техник боловсруулалтын ажил хийх	2021.03.22 2021.03.26	ББНШКомисс
8	2020 оны байнга хадгалах, 70-н жил, түр хадгалах хадгаламжийн нэгжийн данс боловсруулж батлуулах	2021.03.26 2021.03.26	Д Долгоржав
9	2020 оны байнга хадгалах, 70-н жил, түр хадгаламжийн нэгжийн дансыг үдэж хадгалах ажиллах	2021.03.26	Э Бурмаа
10	Батлагдсан төлөвлөгөөний дагуу хадгалах хугацаа нь дууссан баримт бичгийг устгах ажлыг зохион байгуулах болон УБНАрхивын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах арга зүй комиссын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах	2-р улиралд	ББНШКомисс



2020 оны хөтлөгдөж дууссан баримт бичгээ архивт шилжүүлсэн байдал:

д/д	Албан хаагчдын нэрс	Баримт бичгийн тоо	Хуудасны тоо	Тайлбар
1	Ш.Баярмаа	99 боть	24750	Сонгуулийн 96 баримт түр хадгалах 3 боть түр хадгалах нийт 96
2	Б.Цогзолмаа	28 боть	7000	70-н жил

3	Б.Хишгээ	28 боть	7000	70-н жил
4	А.Долгоржав	1 боть	45	Түр хадгалах
5	Э.Жаргалсүрэн	20 боть,1дэвтэр	5000	Түр хадгалах
6	Н.Дарханцэцэг	14 боть,1дэвтэр	3500	Түр хадгалах
7	Д.Ганцэцэг	12 боть,1дэвтэр	3000	Түр хадгалах
8	Ё.Жумаа	11 боть,2 дэвтэр	2750	Түр хадгалах
9	Энхтогтох	14 боть	3500	Түр хадгалах
10	Б.Идэрмөнх	26 боть,4дэвтэр	6500	Түр хадгалах
11	Очмаа /Хонгор сум/	6 боть	1500	Түр хадгалах
12	Сүхбаатар /Орхон сум/	3 боть,2дэвтэр	750	Түр хадгалах
13	О.Мэндбаяр	2 боть,3дэвтэр	500	Түр хадгалах
14	У.Золзаяа	Лавлагаа олгосон бүртгэлийн дэвтэр-2	-	Түр хадгалах
15	Н.Шүрхүү	2 боть	500	Түр хадгалах
16	Э.Бурмаа /бичиг хэрэг/	43 боть	10750	Байнга хадгалах 4 боть, түр хадгалах 39
17	Оюунбилэг /нягтлан/	13 боть	3250	Байнга хадгалах 7 түр хадгалах 6 боть
18	С.Нямпил	13 боть	3250	Түр хадгалах
19	Б.Цогбаяр	7 боть	1750	Түр хадгалах
20	Д.Долгоржав	2 боть	500	ББНШКомиссын тайлан
<b>344 боть , 16 дэвтэр хуудасны тоо 85795</b>				



*ЧБТЭХ*  
Байгууллагын нэр

Архивт хүлээн авсан баримтын бүртгэл № *Нарвал суртал*

Дэс дугаар	Баримт хүлээн авсан он, сар, өдөр	Баримт шилжүүлсэн зорилго, баримтын хөгж, харьцаг газар, хувь хүний нэр	Баримт шилжүүлсэн бүртгэлийн нэр, дугаар	Шилжүүлсэн баримтын он, цагийн хязгар	Бүртгэлтэй ХН-ийн тоо		Бүртгэлтэй ХН-ийн тоо		Хуудас	Тайлбар
					Байнга хадгалах	Түр хадгалах	ХН	КГ		
1	2021.02.20	ЧБТЭХ	Ч.У.ТЭХ	2020 он	6	7	9	9	10	11
2	2021.02.20	ЧБТЭХ	Ч.У.ТЭХ	2020 он		3				
3	2021.02.20	ЧБТЭХ	Ч.У.ТЭХ	2020 он		2				
4	2021.02.20	ЧБТЭХ	Ч.У.ТЭХ	2020 он		1				

Дүн тоо 8... онд (8) хадгаламжийн нэгж хүлээн авав

Архивын ажилтан /гэрхлэгч/ *Д. Дэлгэр* гарын үсэг гарын үсгийн тайлал

2. Тайлангийн хугацаанд хадгалах хугацаа нь дууссан 112 баримт, 13-н дэвтэр /28000 хуудас/ -ийг ангилан ялгалт хийж, хадгалах хугацааны үнэ цэнэ, эрдэм шинжилгээ, техник боловсруулалтын ажлыг хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалт, хадгалах хугацааны салбарын жагсаалтын дагуу нягтлан шалгаж устгах баримт бичгийн актыг үйлдэн БНШК-ын 2021 оны 02-р сарын 01-ний өдрийн 1 дүгээр хурлаар хэлэлцэн баталж, устгах ажлыг зохион байгуулсан.



3. Хадгаламжийн нэгжийн данс бүртгэл, жагсаалтыг шинэчлэн гаргаж батлуулан архивын тавиурын заагуур, заагчийг шинэчлэн хийсэн.

4. Байгууллагын архивын баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээ, хадгалалтын талаарх мэдээг Дархан-Уул аймгийн Төрийн архивт оны эцэст хугацаанд нь гаргаж албажуулан хүргүүлсэн болно.

5. Байгууллагын архивын сан хөмрөгт жилийн эцсийн байдлаар нийт 2656-н баримт бичиг хадгалагдаж байна. Үүнд:

- Байнга хадгалах архивын баримт-169
- 70-н жил хадгалах архивын баримт-136
- Түр хадгалах архивын баримт- 23

## **НАЙМ. АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР**

“Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай” хууль, Архивын Ерөнхий газрын даргын 2021 оны А/07 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”, Стандартчилал Хэмжил зүйн газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн С/30 дугаар баталсан “Баримт бичгийн стандарт”-ын дагуу хэлтсийн албан хэрэг хөтлөлтийн өдөр тутмын үйл ажиллагаа, баримт бичгийг “Able Cloud” системийн “Албан бичиг” программыг ашиглан албан хэргийг хөтөлж байна.

1. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, дүрэм журмын дагуу 201-н өргөдөл бичгээр хүлээн авсан бөгөөд хуулийн хугацаанд нь 195-н өргөдлийг хянан шийдвэрлэж, 6-н өргөдөл шийдвэрлэлтийн хугацаандаа хянан шалгагдаж байна. Тайлант хугацаанд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал 97,01 хувьтай байна.

Хүлээн авсан өргөдлийн тоог 2019, 2020, 2021 онуудын тоон үзүүлэлттэй харьцуулбал:



2. Тайлангийн хугацаанд дээд шатны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, эрх бүхий байгууллагаас ирсэн албан бичиг 1244, хариу явуулсан албан бичиг 1116, нийт 2360-н албан бичиг байна.

Албан бичгийг ирүүлсэн байгууллагаар ангилвал:

- Улсын бүртгэлийн ерөнхий газраас-104
- Дархан-Уул аймаг дахь Цагдаагийн газраас- 291
- Дархан-Уул аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх газар 445, 435-р хорих анги- 231
- Шүүхийн байгууллагаас- 121
- Бусад байгууллагаас- 497

3. Хэлтсийн даргын үндсэн үйл ажиллагаатай холбоотой 19, хүний нөөцтэй холбоотой 9-н тушаалыг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу боловсруулж батлуулан, холбогдох албан хаагчдад танилцуулсан.

4. УБЕГ-аас үндсэн үйл ажиллагаатай холбоотой 34, хүний нөөцтэй холбоотой 18 тушаал, үүрэг даалгавар-3, чиглэл-32, зөвлөмж-2 тус тус баримт бичгийг бүртгэн, албан хаагчдад танилцуулах хуудсаар танилцуулж, биелэлтэд хяналт тавин, хэрэгжилтийг хугацаанд нь холбогдох газарт хүргүүлсэн.

5. Албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу ирсэн, явуулсан албан бичиг өргөдөл, гомдлыг тухай бүрд цахим болон цаасан хэлбэрээр бүртгэн Able програмд сканердан оруулж хяналтын карт хөтлөн удирдлагад танилцуулж ажилласан.

6. Тамга, тэмдэг шинэчилсэнтэй холбоотой тайлант хугацаанд явуулсан бичигт боловсруулсан тэмдэг дарж холбогдох албан тушаалтнаар гарын үсэг зуруулж баталгаажуулан, ирсэн бичигт хүлээн авсан тамга дарж, бичилт хийн бүртгэлийн дэвтэр хөтлөн хадгаламжийн нэгж үүсгэн дэс дарааллаар дугаарлан цэгцэлж БНШК-д хуулийн хугацаанд нь хүлээлгэн өгөх бэлтгэл ажлыг хангасан.

7. 2021 онд тус хэлтэст ирсэн болон явуулсан албан бичиг, өргөдөл гомдлыг холбогдох баримтын хамт сар бүр скайнердан цахим сан үүсгэн хадгалж байна.

8. УБЕГ болон бусад байгууллагаас цахим сүлжээгээр ирүүлсэн чиглэл, үүрэг даалгавар, зөвлөмжийг хэвлэн авч дэс дарааллын дагуу хадгаламжийн нэгж үүсгэн ажиллаж байна.


Судалгаа, мэдээ тайлангийн чиглэлээр:

1. 2021 оны байдлаар нийт 11-н судалгаа гаргаж холбогдох газарт хүргүүлсэн.
2. УБЕГ-ын Тамгын газарт өргөдөл, гомдлын мэдээг улирал тутамд, хагас жилийн тайланг мэдээг батлагдсан загварын дагуу хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.
3. Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэст 7 хоног, сар бүрийн тоон мэдээг нэгтгэн гаргаж хугацаанд нь цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлсэн.
4. Үнэт цаасны тайланг сар бүрийн 25-наар тасалбар болгон Улсын бүртгэлийн ерөнхий газрын санхүү аж ахуйн хэлтэст хугацаанд нь хүргүүлсэн.
5. Цар тахалтай холбогдуулан өдөр тутмын үйл ажиллагааны мэдээг тогтоосон буюу 15.00 цагаас хугацаа хэтрүүлэлгүй хүргүүлэн ажилласан.
6. 2021 оны 11 дүгээр сарын 11-ээс 29-ний өдрүүдэд дархлаажуулалтад хамрагдсан албан хаагчдын тоон мэдээг [T.Ganjargal.burtgel.gov.mn](http://T.Ganjargal.burtgel.gov.mn) цахим хаягаар хугацаанд нь хүргүүлэн ажилласан.


Тайлант хугацаанд хугацаа хожимдуулсан албан бичгийн хариу, тайлан, мэдээ, судалгаа, байхгүй болно.

Архивын чиглэлээр:

2020 оны баримтуудыг холбогдох журмын дагуу хадгаламжийн нэгж болгон нийт 42 боть баримтыг БНШК-д хүлээлгэн өгсөн.



Тайлант хугацаанд ирсэн албан бичиг, явуулсан албан бичиг болон боловсруулсан төсөл, хяналтын картыг дэс дарааллаар нь цэгцэлж дугаарлан БНШК-т хүлээлгэн өгөхөд бэлэн болгосон.



**Дотоод зохион байгуулалтын ажлын хүрээнд:**

Тайлант хугацаанд даргын зөвлөлийн хурал 11, албан хаагчдын 7-н удаа зохион байгуулагдсан бөгөөд холбогдох хурлын тэмдэглэлийг хөтөлж баталгаажуулсан.

Хэлтсийн хариуцлагатай жижүүрийн хуваарийг гаргаж хэлтсийн даргаар батлуулан албан хаагчдад танилцуулах, гадуур ажлын дэвтэрт бүртгэл хөтлөлтөд хяналт тавин ажилласан.

**ЕС. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААР**

1.Тайлант хугацаанд тус хэлтсийн батлагдсан төсөв **378,9 сая.төгрөг**, 2021 оны 11 сарын байдлаар үндсэн үйл ажиллагааны санхүүжилт **375,2 сая.төгрөг**, Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулах нэмэлт санхүүжилт **45,4 сая.төгрөг**, нийт **420,6 сая.төгрөг**ийг төсвийн хуваарийн дагуу зарцуулан ажилласан байна.

№	Арга хэмжээний нэр	Батлагдсан төсөв /2021.11 сар/	Зарцуулалт /2021.11 сар/	Хэмнэлт
1	Үндсэн үйл ажиллагааны санхүүжилт	375,226,600	357,022,545	18,204,055
2	Нэмэлт санхүүжилт	45,418,600	45,418,600	-
<b>Дүн</b>		<b>420,645,200</b>	<b>402,441,145</b>	<b>18,204,055</b>

Хэмнэгдсэн зардал нь цалингийн зардал бөгөөд тайлант хугацаанд 3-н орон тоо дутуу ажилласантай холбоотойгоор хэмнэгдсэн байна.

## 2.Орлого төвлөрүүлэлт:

/Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт сүүлийн 3 жилийн үзүүлэлт/

№	Он	Төлөвлөгөө	Биелэлт		Хувь
			Төвлөрүүлсэн орлого	Гэрэгэ киоск	
1	2019	350.0	439,46		125.6
2	2020	350.0	381,98		109.1
3	2021	350.0	268.49	116,97	110,1

Тайлант хугацаанд шинэ төлбөрийн систем болох Гэрэгэ киоск төхөөрөмжийг нэвтрүүлсэн. Үйлчилгээний төлбөрийг Гэрэгэ киоск төлбөрийн системээр төлснөөр УБЕГ-ын орлогын данс, улсын бүртгэлийн хэлтсийн орлогын данс руу тус тус төвлөрүүлсэн байна. Хэлтсийн дансанд төвлөрүүлсэн үйлчилгээний орлого нь **268,49 сая** төгрөг, гэрэгэ киоск төхөөрөмжөөр төлөгдсөн үйлчилгээний орлого **116,97 сая** төгрөг, нийт тайлант хугацааны орлого **385,46 сая** төгрөг буюу **110,13 хувиар** орлогын төлөвлөгөө биелсэн байна.

## 3.Мэдээ тайлангийн чиглэлээр:

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, үйлчилгээний орлогын мэдээ, үнэт цаасны тайланг сар бүр гаргаж, санхүүгийн тайланг тодруулгын хамт улирал бүр УБЕГ-ын Санхүү аж ахуйн хэлтэст хугацаанд нь гарган цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлсэн болно.

Үнэт цаас, маягтыг үр ашигтай хэмнэлттэй зарцуулахад хяналт тавьж хүчингүй болсон үнэт цаасны төлбөрийг сар бүр барагдуулж ажилласан. Бүртгэгч нартай тооцоо нийлж хийсэн бүртгэлийн тоогоор нь төлбөр хураамжийг нэг бүрчлэн тулган баталгаажуулсан.

2020, 2021 оны батлагдсан төсөвт шуудан холбооны зардал хүрэлцээгүйгээс **2,877,412** төгрөгийн өр үүссэнийг УБЕГ-ын Санхүү, аж ахуйн хэлтэст хандан тооцоо нийлсэн акт, нэхэмжлэхийг хүргүүлэн төсвийг шийдвэрлүүлсэн.

## 4.Аудитын зөвлөмжийн хэрэгжилт:

Хэлтсийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын байгууллагаар аудит хийлгэж **“ЗӨРЧИЛГҮЙ”** санал дүгнэлт авсан.

Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг ханган 2021 оны 05 дугаар сарын 31 өдөр 501 тоот албан бичгээр төрийн аудитын газарт хүргүүлсэн.

Зөвлөмжийн биелэлт: 2019 оны 3 сард 5,953,500, 9-р сард 5,102,900, 11,907,000, 12-р сард 5,953,500 төгрөгийн 4-н гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд нөхөж мэдээлсэн.


Актын биелэлт: Тус хэлтсийн албан хаагчдын ээлжийн амралтын цалингийн илүү олговрыг 2021 оны 3,4,5 дугаар сарын цалингаас 16 албан хаагчаас 1055.9 мян.төгрөгийг суутгаж төсөвт буцаан төвлөрүүлсэн.

### 5.Шилэн данс:


Шилэн дансны веб сайтад байгууллагын холбогдох мэдээллийг бүрэн байршуулж ажиллалаа. Эхний 11 сарын байдлаар шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулсан бөгөөд 133 мэдээллээс 133 мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж эхний 3н улирлын тайланг [shilendans@mof.gov.mn](mailto:shilendans@mof.gov.mn) цахимаар хугацаанд нь илгээсэн.

### АРАВ: МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР

1. <https://darkhan-uul.burtgel.gov.mn/> сайтад 11 сарын 30-ний байдлаар 85-н мэдээлэл байршуулж иргэн, хуулийн этгээдэд мэдээ мэдээллийг хүргэсэн байна.



2. Дархан-Уул аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс facebook хуудсанд 11 сарын 30-ний өдрийн байдлаар Улсын бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой 510-н мэдээлэл байршуулж, 35000 мянга гаруй иргэнд мэдээлэл хүрсэн байна.




3. Иргэний бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, Хуулийн этгээдийн бүртгэл, Архивын чиглэлээр 2021 оны 1-11 дүгээр сарын инфографик мэдээллийг

11 удаа гаргаж <https://darkhan-uul.burtgel.gov.mn/> сайт болон [Дархан-Уул аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс](#) Facebook page хуудсанд тухай бүр байршуулж мэдээллийг түгээж ажилласан.



4. “Юнителийн 4G router” төхөөрөмжийг УБЕГ-аас хүлээн авч Орхон, Шарын гол сумдыг улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээнд холбох ажлыг хийж гүйцэтгэсэн.



5. Иргэний бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, Хуулийн этгээдийн бүртгэл, Нэгдсэн архивын мэдээллийн сан системүүд болон сүлжээний ажиллах хэвийн байдлыг бүрдүүлэн сүлжээнд алдаа гарах, тасрах зэрэг тохиолдолд техникийн саатлуудыг засаж тухай бүрд холбогдох арга хэмжээг аван бүртгэлийн үйлчилгээг хэвийн явуулах боломжийг бүрдүүлэн ажилласан.



6. Хэлтсийн дотоод сүлжээний аюулгүй байдлыг хангах хүрээнд илүү ашиглах шаардлагагүй сүлжээний кабел утаснуудыг цэгцэлж, шинээр ил гарсан утаснуудыг далдалсан.

7. Цахим мэдээллийн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журмын хэрэгжилтийг хангах хүрээнд хэлтсийн албан хаагчдад Мэдээлэл технологийн зөвлөмж зөвлөгөөг тогтмол танилцуулж хэрэгжилтийг хянан ажиллаж байна.

8. Хэлтсийн үйлчилгээнд ашиглагдаж байгаа интернетэд холбогддог нийт 7-н компьютерт 1 жилийн лицензтэй Kaspersky вирусны програм суулгасан.

9. Тус хэлтсийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нийт 26-н компьютер, 26-н принтер, 8-н скайнер, 6-н зургийн аппарат, 6-н хээ уншигч төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг хангаж тухай бүр нь засвар үйлчилгээг хийж байна. Үйлдлийн систем доголдсон 5-н компьютерыг форматалж шинээр үйлдлийн систем суулгаж хэвийн ажиллагааг ханган ажилласан.

10. Улсын бүртгэгч П.Золзаяагийн Иргэний үнэмлэхний зураг татах програм PhotoImport болон зураг засварын Photoshop програмыг ашигладаг суурин нь компьютерт суулгаж хэвийн ажиллагааг хангасан.

11. 2021 оны 08 дугаар сарын 20-21-ний өдөр зохион байгуулагдсан Мэдээлэл технологийн ажилтны нэгдсэн сургалтад хамрагдаж, Улсын бүртгэлийн ерөнхий газар БНСУ-ын Солонгосын олон улсын хамтын ажиллагааны байгууллага буюу КОЙКА-гийн буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй “Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих төсөл”-ийн хүрээнд техник, тоног төхөөрөмж болох компьютер, олон үйлдэлт принтер, хурууны хээ уншигч, зургийн аппаратыг 2021 оны 09 сарын 16-нд хүлээн авсан.


Хэлтсийн хэмжээнд суурин компьютер 6, дэлгэц 6, зургийн аппарат 6, хурууны хээ уншигч 6, мемори карт 6, гурван үйлдэлт принтер 6 тус тус хүлээн авсан бөгөөд үүнээс 4 сумын улсын бүртгэгчийн албан хэрэгцээнд ашиглагдах тоног төхөөрөмжийг сумдын улсын бүртгэгч нарт актын дагуу хүлээлгэн өгсөн.

Тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгөхдөө хуучин зөөврийн компьютер дээрх Civilreg offline програмын баазыг хуулан, принтерийн инсталл, Mozilla firefox chrome browser-үүдийг суулган шаардлагатай бүх програмыг таниулж суулган өгсөн.

Дархан-Уул аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн тоног төхөөрөмжийн шинэчлэлт

Д/д	Сумын нэр	Компьютер /Иж бүрэн /	3 үйлдэлт принтер	Зургийн аппарат	Хурууны хээ уншигч	Хүлээн авсан байдал	Гарын үсэг
1	Дархан сум	1	1	1	1	Авсан	
2	Дархан сум	1	1	1	1	Авсан	
3	Дархан сум	1	1	1	1	Авсан	
4	Орхон сум	1	1	1	1	Авсан	С.Баатар
5	Шарын гол сум	1	1	1	1	Авсан	Бүртгэлийн хэлтсийн дарга
6	Хонгор сум	1	1	1	1	Авсан	А.Орлова






12. Албан хаагчдын ашиглаж байгаа компьютер болон програмуудын нууц үгийг улирал тутамд заавал өөрчилж, өөрчилсөн талаар бүртгэл хөтлөн, гарын үсэг зуруулан баталгаажуулан ажиллаж байна.

Албан хаагчдын компьютерын нууц үгийг сольсон бүртгэл

Д/д	Албан хаагчдын нэрс	Албан тушаал	1 дүгээр улирал		2 дугаар улирал		3 дугаар улирал		4 дүгээр улирал		Гарын үсэг
			тнйм	үгүй	тнйм	үгүй	тнйм	үгүй	тнйм	үгүй	
1	М Хувьсана	Хэлтсийн дарга	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	<i>[Handwritten signatures and initials]</i>
2	Б Цогзолмаа	Хяналтын улсын байцагч	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	
3	Ш Баярмаа	Ахлах бүртгэгч	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	
4	О Мандбаяр	Ахлах бүртгэгч	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	
5	Ц Сньюнбилэг	Нагтлан Бодогч	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	
6	Д Мөнхсан	МТА	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	
7	М Уянга	Улсын бүртгэгч	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	
8	Н Бэхбат	Улсын бүртгэгч	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	
9	Н Шүрхүү	Улсын бүртгэгч	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	
10	Л Соёлмаа	Улсын бүртгэгч	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	
11	Э Бурмаа	Венес хэрэг	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	
12	А Болормаа	Архив	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	
13	У Эгэлмаа	Улсын бүртгэгч	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	
14	Б Жумав	Улсын бүртгэгч	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	
15	Д Гантува	Улсын бүртгэгч	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	
16	Г Энхтөгтох	Улсын бүртгэгч	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	
17	А Долгоржав	Улсын бүртгэгч	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	
18	Н Дарханцэцэг	Улсын бүртгэгч	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	
19	Д Ганцал	Улсын бүртгэгч	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	
20	Э Жаргалсуурэн	Улсын бүртгэгч	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	
21	Д Долгоржав	Архив	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	
22	С Сүхбаатар	Улсын бүртгэгч	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	
23	А Снмаа	Улсын бүртгэгч	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	
24	Б Цогбаяр	Улсын бүртгэгч	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	
25											
26											
27											
28											
29											

Бүртгэл хөтөлсөн: *[Signature]* МТА Д.Мөнхсан  
2021 он

13. Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан 20, аймаг орон нутгаас зохион байгуулсан 16, дотооддоо зохион байгуулсан 7, **НИЙТ-43** удаагийн Online сургалтын холболтыг тухай бүр хийж тасралтгүй хэвийн ажиллагааг хангаж сургалтад хамрагдах боломжийг бүрдүүлэн ажилласан.



14. Үйлчилгээний зааланд байрших дэлгэцээр улсын бүртгэл, авилга, ашиг сонирхолтой холбоотой видео шторк болон E-mongolia системээс хэрхэн үйлчилгээ

авах болон бусад мэдээ мэдээллийг цаг тухай бүр нь иргэдэд тогтмол сурталчлан ажиллахад техникийн хэвийн ажиллагаа ханган ажилласан.



15. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулиар хэсгийн хороодод ажиллах Улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтнууд сонгуулийн ирц бүртгэлийн программд ажиллах дадлага сургалтыг УБЕГ-ын сургалтын багтай хамтран зохион байгуулсан.



16. Ажилчдын цагийн бүртгэлийг цаг бүртгэлийн системээр дамжуулан <https://www.intranet.gov.mn/> програмаас татаж авч нягтлан бодогчид сар хэвлэн өгч байна.

intranet.gov.mn/main.php?p=dGlt9VZhY2Nlc3M=

Хүний нөөц Ажил хэрэг Зөвхөд Албан биелэг Цаг бүртгэл Төсөл, хөтөлбөр Хурал Олон нийтийн Үр дүнгийн гарса Бусад

**able**  
Цаг бүртгэл

Улсын бүртгэлийн хэлтэс

Ургэрийн бүртгэлийн тасаг  
Зд хөрөнгийн эрхийн бүр...  
Халтсийн дарга  
Нэрвэ, биелг хэргийн аж...  
Хяналтын улсын байцаагч  
Зд хөрөнгийн эрхийн бүр...  
Зд хөрөнгийн эрхийн бүр...  
Иргэний бүртгэлийн улс...  
Хуулийн этгээдийн улс...  
Сүүлч улсын бүртгэгч  
Ахлах нягтлан бодогч  
Архивч, мэдээллийн техн...  
Архивч  
Гэрээт албан хаагч

Эзлэхийн хуваарь  
Хүсэлт

Шуудан цагийн хуваарь (1)  
Эзлэхийн хуваарийн график (0)  
Эзлэхийн цагийн хуваарь (0)  
Бусад төлөрсөө >

Код	Ажилтны нэр	Албан тушаал	Ирсэн	Явсан	Таслалт	Торгуулт	Төлөв
000003	А.Болормаа	Нэрвэ, биелг хэргийн	[?]	[?]	00	00	
000005	Б.Хишгээ	Хяналтын улсын байг...	[?]	[?]	00	00	
000015	Б.Цогзолмаа	Хяналтын улсын байг...	[?]	[?]	00	00	
000002	О.Мандахар	Зд хөрөнгийн эрхийн	[?]	[?]	00	00	
000012	М.Ужиг	Зд хөрөнгийн эрхийн	[?]	[?]	00	00	
000009	Л.Сойлмаа	Зд хөрөнгийн эрхийн	[?]	[?]	00	00	
000013	Н.Шүрүү	Зд хөрөнгийн эрхийн	[?]	[?]	00	00	
000019	Н.Байбат	Зд хөрөнгийн эрхийн	[?]	[?]	00	00	
000006	Ш.Баярмаа	Иргэний бүртгэлийн у	[?]	[?]	00	00	
000025	Э.Жаргалсүрэн	Иргэний бүртгэлийн у	[?]	[?]	00	00	
000007	Н.Дарсанцэцэг	Иргэний бүртгэлийн у	[?]	[?]	00	00	
000010	С.Мялал	Иргэний бүртгэлийн у	[?]	[?]	00	00	
000011	П.Золзаяа	Иргэний бүртгэлийн у	[?]	[?]	00	00	
000022	Б.Идэрмөнх	Иргэний бүртгэлийн у	[?]	[?]	00	00	
000018	Г.Энхтөгтох	Иргэний бүртгэлийн у	[?]	[?]	00	00	
000020	А.Долгоржав	Хуулийн этгээдийн ул	[?]	[?]	00	00	
000016	Ц.Оюунбилэг	Ахлах нягтлан бодогч	[?]	[?]	00	00	Эзлэхийн аявралт биелэг
000024	Т.Лхагва-Очир	Ахлах нягтлан бодогч	[?]	[?]	00	00	
000001	Д.Мөнхсан	Архивч, мэдээллийн т	[?]	[?]	00	00	

17. Нэг давхрын үйлчилгээний заалны 3 ширхэг камер болон 2 давхрын 3 ширхэг камер, үл хөдлөхийн архивын 1 ширхэг камер нийт 7 ширхэг камерын ажиллагаанд хяналт тавьж ажиллаж байна.




**АРВАН НЭГ: УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ОЛОН НИЙТЭД СУРТАЛЧЛАХ, ИРГЭДИЙН ЭРХ ЗҮЙН МЭДЛЭГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД**

1. Хэлтсийн үйлчилгээний зааланд байрлах Led дэлгэцээр иргэдэд, хуулийн этгээдийн улсын бүртгэл, авилга ашиг сонирхолтой холбоотой видео шторк,болон E-Mongolia системээс хэрхэн үйлчилгээ авах болон, аймаг орон нутгийн холбогдолтой мэдээ мэдээллийг цаг тухай бүр нь иргэдэд тогтмол сурталчлан ажиллаж байна.



2. Хэлтсийн үйлчилгээний зааланд байрлах Led дэлгэцээр иргэдэд, улсын бүртгэл, авилга ашиг сонирхолтой холбоотой видео шторк,болон E-Mongolia системээс хэрхэн үйлчилгээ авах болон, аймаг орон нутгийн холбогдолтой мэдээ мэдээллийг цаг тухай бүр нь иргэдэд тогтмол сурталчлан ажиллаж байна.



3. Хэлтсийн ажлын байранд байрлах “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”, Дархан зах дотор байрлах “Нийтийн үйлчилгээний нэгдсэн төв” –д иргэдэд зориулсан гарын авлагыг бэлтгэн байрлуулж, иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж буй цонхнуудад үйлчилгээ үзүүлж буй бүртгэлийн төрлүүдийг иргэдэд ойлгомжтой байдлаар байршуулсан.




4. Дархан-Уул аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас Гэр бүлийн тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдөр 7 байгууллагын төлөөллийг оролцуулан зохион байгуулсан “**Гэр бүл салалтын өнөөгийн нөхцөл байдал, түүнийг бууруулахад хамтын үйл ажиллагааг сайжруулах нь**” сэдвээр зохион байгуулсан хэлэлцүүлэгт тус хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга оролцож гэрлэсний болон гэрлэлт дуусгавар болсны бүртгэлийн тоон судалгаагаар мэдээлэл хийж оролцлоо.



5. Хэлтсийн мэдээллийн самбар болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбогдолтой хууль тогтоомж, бүрдүүлэх материалын жагсаалтыг нэг бүрчлэн гаргасан самбарыг тусад нь байршуулан холбогдох мэдээ, мэдээллүүдийг тухай бүр шинэчлэн ажиллаж байна.




6. Бүрдүүлэх материалын жагсаалт, өргөдлийн загварыг шинэчлэн, иргэд үйлчилгээ авахад ойлгомжтой байдлаар бэлтгэн үйлчилгээний зааланд байршуулан ажиллаж байна.



7. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн Улсын бүртгэгч Л.Соёлмаа нь Капитрон, Голомт, Хаан, Хас, Ариг, Төрийн банк, Банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн эдийн засагч нарт банкнаас ирүүлж байгаа Эд хөрөнгийн барьцааны гэрээний бүртгэлтэй холбоотой алдаа, зөрчил дутагдал болон бүртгэл хийхэд хүндрэл учруулж буй асуудлаар мэдээ, мэдээлэл зөвлөмжийг өгч ажиллалаа.



8. Хуулийн этгээдийн оноосон нэр баталгаажуулах , E-Mongolia системд хэрхэн нэвтэрч үйлчилгээг хэрхэн авах талаар мөн бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтыг хэрхэн авах тухай нээлттэй Live хийсэн.



9. Хөгжлийн шийдэл” ТББ, Татварын хэлтэс, Санхүү төрийн хэлтэстэй хамтран иргэн, хуулийн этгээдэд 3 удаагийн уулзалт сургалт, мэдээллийг онлайнаар зохион байгуулсан.



### **АРВАН ХОЁР: ХҮНИЙ НӨӨЦ СУРГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Дархан-Уул аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын бүтэц орон тоог баталсан тушаалын дагуу төрийн захиргааны 5, төрийн үйлчилгээний 22, гэрээт ажилтан 2 нийт 29 албан хаагчидтайгаар аймгийн 130,0 мянга гаруй иргэнд бүртгэлийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна. 2021 оны байдлаар улсын бүртгэгч нарын мэдлэг чадварыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулагдсан дараах сургалтуудад нийт албан хаагчдыг хамруулан ажиллалаа.

#### ***Иргэний бүртгэлийн чиглэлээр:***

1. 2021 оны 2 дугаар сарын 01-нээс 19-ний өдрүүдэд Удирдлагын академиас зохион байгуулсан Монгол улсын хөгжлийн бодлого: төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ “Алсын хараа-2050” сэдэвт богино хугацааны сургалтад хэлтсийн дарга, улсын ахлах бүртгэгч нар хамрагдсан.

2. 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдөр хэлтсийн нийт албан хаагчид болон итгэмжлэгдсэн ажилтнуудад аймгийн тагнуулын хэлтэстэй хамтран цахимаар “Төрийн нууц, байгууллагын нууцын” тухай сэдвээр сургалт зохион байгуулсан.

3. Монголын Үндэсний Техникийн их сургуулийн Бямба, Ням гарагийн “Эрх зүйн бакалаврын эчнээ” ангид иргэний 3 улсын бүртгэгч 2021 оны хичээлийн жилээс эхлэн суралцаж байна.

4. Тайлангийн хугацаанд Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системээр зохион байгуулагдсан 8 удаагийн цахим, 2 удаагийн танхимын сургалтад холбогдох албан хаагчдыг бүрэн хамруулан оролцсон.

5. Улсын бүртгэгч нарт бүртгэлийн хууль тогтоомжийг нэг мөр ойлгуулах хүрээнд 2, гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах сэдвээр 2 удаа тус тус танхимаар, аймгийн ХЭЗХ-тэй хамтран “Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг цахимаар зохион байгуулсан.

6. Гуравдугаар улиралд УБЕГ-аас зохион байгуулсан бүсийн сургалтад улсын бүртгэгч нарыг бүрэн хамруулан оролцсон.



*Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр:*

1. 2021.03.17-ны өдрийн УБЕГазраас зохион байгуулсан “Лавлагаа, үнэт цаас олголт” сэдэвт онлайн сургалт,
2. 2021.03.31-ны өдрийн УБЕГазраас зохион байгуулсан “Эрхийн улсын бүртгэлд урьдчилсан тэмдэглэл хийх, хүчингүй болгох, Хуулийн этгээдийн улсын бүртгэлд хориг тавих, цуцлах бүртгэлд анхаарах асуудлууд” онлайн сургалт,
3. 2021.06.10-ны өдрийн Архивын ерөнхий газраас зохион байгуулсан “Төрийн албаны тухай болон Архив албан хэрэг хөтлөлт” сэдэвт онлайн сургалт,
4. 2021.06.25-ны өдрийн УБЕГазраас зохион байгуулсан “Хүний эрхийг хангах үндэсний хэрэгжилт ”онлайн сургалт
5. 2021.07.06-ны өдрийн АЗДГТГазраас зохион байгуулсан “Үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт, хяналт шинжилгээ үнэлгээ” сэдэвт онлайн сургалт
6. 2021 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан /орон нутгийн Улсын бүртгэгч нарт зориулсан бүсчилсэн сургалт/
7. 2021.09.21-ны өдрийн Авилгатай тэмцэх газраас зохион байгуулсан “Хөгжлийн шийдэл төрийн бус байгууллагын бэст хөтөлбөр” сэдэвт онлайн сургалт
8. 2021.09.22-ны өдрийн УБЕГазраас зохион байгуулсан “ Албан хэрэг хөтлөлт” сэдэвт онлайн сургалт
9. 2021.10.14-ны өдрийн “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх” сэдэвт онлайн сургалт
10. 2021.10.15-ны өдрийн Авилгатай тэмцэх газраас зохион байгуулсан “Авилгын эсрэг” онлайн сургалт
11. 2021.10.21-ны өдрийн УБЕГазраас зохион байгуулсан “Галын аюулгүй байдал” сэдэвт онлайн сургалт,
12. 2021.11.10-ны өдрийн УБЕГазраас зохион байгуулсан “Ахмад настны хөгжил, хамгаалал”сэдэвт онлайн сургалт
13. 2021.11.17-ны өдрийн Архивын ерөнхий газраас зохион байгуулсан “ Баримт бичгийн стандарт” сэдэвт онлайн сургалт
14. 2021.11.25-ны өдрийн Авилгатай тэмцэх газраас зохион байгуулсан “Авилгын эсрэг” онлайн сургалтуудад тус тус хамрагдсан.

*Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр:*

1. Бүртгэлийн үйл ажиллагааг нэг ойлгуулах хүрээнд гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах сэдвээр 2 удаа танхимаар, аймгийн ХЭЗХ-тэй хамтран “Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтыг цахимаар оролцсон.

2. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газраас 2021 оны 06 сарын 17-ны өдөр Үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа захирамж, хэм хэмжээний актад оруулсан нэмэлт өөрчлөлтүүд сэдвээр онлайн сургалтад хамрагдсан.

3. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газраас 2021 оны 11 сарын 18-ны өдөр бүртгэлийн чиглэлээр тулгамдаж байгаа асуудал, шалгалтаар илэрсэн нөхцөл байдлыг танилцуулж, цаашид анхаарах асуудлын талаар онлайн сургалтад хамрагдсан.

4. 2021.06.25-ны өдрийн УБЕГазраас зохион байгуулсан “Хүний эрхийг хангах үндэсний хэрэгжилт” онлайн сургалтад хамрагдсан.

5. 2021.09.21-ны өдрийн Авилгатай тэмцэх газраас зохион байгуулсан “Хөгжлийн шийдэл төрийн бус байгууллагын бэст хөтөлбөр” сэдэвт онлайн сургалтад хамрагдсан.

6. 2021.10.14-ны өдрийн “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх” сэдэвт онлайн сургалт

7. 2021.10.21-ны өдрийн УБЕГазраас зохион байгуулсан Авилгатай тэмцэх газраас зохион байгуулсан онлайн сургалт

8. 2021.11.25-ны өдрийн “Гэр бүлийн зөвлөл”-өөс зохион байгуулсан сургалт Лектор Х.Эрдэнэпилийн “Найрсаг үйлчилгээ” сэдэвт уулзалт ярилцлагад хамрагдсан.



9. “Эртэч бүртгэлийнхэн” өглөөний уулзалтын хүрээнд албан хаагчдад Emongolia цахим сайтанд хэрхэн нэвтэрч хуулийн этгээдийн оноосон нэр баталгаажуулах, лавлагаа авах, холбогдох бичиг баримтыг бүрдүүлэх талаар ярилцаж зөвлөгөө мэдээлэл өгсөн.





Хэлтсийн хэмжээнд онлайн болон цахимаар 34-н сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 298-н албан хаагч хамрагдаж сургалтын төлөвлөгөөний биелэлт 100 хувь хэрэгжсэн байна.

### **АРВАН ГУРАВ: НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ**

Хэлтсийн байр, иргэд олноор цуглардаг Дархан зах худалдааны төвүүд болон Шарын гол суманд, нийтдээ 5-н удаа нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж улсын бүртгэлийн үйлчилгээ, иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх, холбогдох гарын авлага тараах, иргэдийн гар утсанд E-Mongolia аппликейшныг суулгаж бүртгэлийн үйлчилгээ авах зааврыг зааж өгөх зэрэг ажлыг хийж гүйцэтгэн нийтдээ 221-н иргэнд бүртгэлийн үйлчилгээг үзүүлж 591-н иргэнд гарын авлага материал тарааж 123-н иргэнд И-Монголиа аппликейшныг утсанд суулгаж өгч ажилласан.

[Нээлттэй хаалганы өдөрлөг-1](#)

[Нээлттэй хаалганы өдөрлөг-2](#)



[Нээлттэй хаалганы өдөрлөг-3,4](#)




[Нээлттэй хаалганы өдөрлөг-5](#)



**АРВАН ДӨРӨВ: ОРОН НУТГИЙН БОЛОН БУСАД  
БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН БАЙДАЛ:**

Төрийн байгууллагууд, банк болон банк бус санхүүгийн байгууллагуудтай бүртгэлийн талаарх хууль тогтоомжийг ойлгох, түүнийг хэрхэн хэрэгжүүлэх талаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

1. Орон нутгийн удирдлагын дэмжлэгтэйгээр 1 дүгээр сард Гэрэгэ Киоск машиныг /3,5 сая үнийн дүн бүхий/ үйлчилгээний зааланд байршуулсан.



2. Улсын бүртгэгчийг тогтвор суурьшилтай ажиллах, нийгмийн баталгааг хангах үүднээс Шарын гол сумын Засаг даргад хүсэлт гарган тус сумын бүртгэгчийг тухайн сумын ЗДТГ-ын албан хаагчдын орон сууцанд сарын түрээсийн төлбөр төлөхгүйгээр /сард- 120,000 төгрөг / амьдрах боломжоор хангасан.

3. Шарын гол сумын улсын бүртгэгчийн ажлын байранд засвар үйлчилгээг хийж өгөх талаар сумын Засаг даргад хүсэлт тавьж 4.350,000 төгрөгийн засварыг хийлгэн, 200,000 төгрөгийн үнийн дүн бүхий шалны хулдаасыг хэлтсийн хамт олны дэмжлэгээр авч өгөн ажлын байрны ажиллах нөхцөл бололцоог сайжруулан ажилласан.



4. Хэлтсийн байрны газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр аймгийн Засаг даргад хүсэлтийг уламжилсан бөгөөд Аймгийн газар зохион байгуулалтын 2021 оны ерөнхий төлөвлөлтөд тусгагдсан газар нь Улсын бүртгэлийн хэлтсийн байр барихад алслагдмал, инженерийн шугам сүлжээг шийдвэрлэхэд хүндрэлтэй байх тул ГХБХБ газрын даргад хамгийн тохиромжтой газрыг судалж танилцуулан 2022 оны эхний захирамжаар шийдвэрлүүлэхээр төслийг бэлдэж танилцуулахыг үүрэг болгосон. /хэмжээний хувьд 1.200м<sup>2</sup>-аас багагүй байхаар Аймгийн Засаг даргатай хэлэлцэн тохирсон болно/

5. Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газраас 2021 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн 163 дугаартай “Хамтран ажиллах тухай” албан бичиг ирсний дагуу Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нар, газрын даамал, газар өмчлөл хариуцсан мэргэжилтнүүдийг оролцуулан шинээр Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн журмын 8 дугаар зүйлийн 8.2.2-т “газрын хэмжээнд өөрчлөлт орсон тохиолдолд тухайн шатны засаг даргын захирамж, газрын төлөв хянан баталгааны дүгнэлтийг авахаар журамласныг” тайлбарлан харилцан мэдээлэл солилцсоноор сүүлийн өмчлөгчөөр хэмжээнд өөрчлөлт орсноор захирамж гаргах, 10 метр.кв талбай доторх өөрчлөлтийг кадастрын зурагт тэмдэглэгээ хийхээр зохицуулсан нь иргэд захирамж хүлээн хугацаа алдалгүй шуурхай үйлчлүүлэх нөхцөлийг бий болгосон уулзалт боллоо.

6. Мөн 2014 онд батлагдсан хаягжилтын тухай хуулийг нэгдсэн ойлголтоор хэрэгжүүлэхэд анхаарч төвийн болон гэр хорооллын гудамжны хаягийг хэрхэн дугаарлах тал дээр хамтран ажиллах тухай Хаяг олгох эрх бүхий байгууллага болох Дархан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Я.Бат-Очирт 2021.02.01-ний өдрийн 155 дугаартай албан бичиг хүргүүлснээр шинээр батлагдан гарсан тогтоолын эх хувийг хавсралтын хамт баталгаажуулан тус хэлтэст ирүүлдэг болсон нь хаягийн талаар маргаан гаргах явдлыг арилгасан ажил боллоо.

7. Дархан сумын “Сум хөгжүүлэх сан”-аас олгодог зээлийн болон барьцааны гэрээ “Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангадаггүй, барьцаалбарыг буруу үйлддэг, өмчлөгчийн мэдээлэл, хаягийг гэрээнд андуурч шивдгээс иргэд олон дахин буцаж чирэгдэл үүсч байгаа тухай 2021.06.25-ны “Хамтран ажиллах тухай” 606 дугаартай албан бичгийг хүргүүлэн зээл хариуцсан мэргэжилтэнд сургалт мэдээлэл өгснөөр гэрээ буцах явдал арилсан.


8. Дархан Уул аймгийн хэмжээнд ашиглалтад орсон орон сууцыг хүлээн авч Улсын комиссын актыг үйлдэхдээ тухайн орон сууцын 1 дүгээр давхар болон зоорийн давхрын зориулалт, автомашины тоог тодорхой бичдэггүйгээс барилгын гүйцэтгэгч, захиалагчийн дунд маргаан үүсч хууль хяналтын байгууллагаар шалгагддаг байсныг Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын Барилгын ахлах мэргэжилтэн улсын комиссын нарийн бичгийн дарга О.Ундрахтай харилцан хууль тогтоомжийн хүрээнд шаардлага хангасан акт үйлдэж байх талаар хамтран ажиллаж байна.

9. Дархан Уул аймгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлдэг Төрийн банк, Худалдаа хөгжлийн банк, Хас, ХААН банкны эдийн засагч эрхлэгч нартай 2021.04.02-ны өдрийн 398 дугаартай албан бичгийн хүрээнд хуульд заасны дагуу барьцааны гэрээ үйлдэх, өмчлөгчийн зөвшөөрлийг авах, хаягжилтын дагуу гэрчилгээг сольж шинэчлэх ажил дээр хамтран ажиллах талаар Хяналтын улсын байцаагч, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн эрхийн ахлах бүртгэгчийн бүрэлдэхүүнтэй очиж мэдээлэл солилцлоо.


### АРВАН ТАВ. ИЛ ТОД БАЙДАЛ:

Тус хэлтэс нь үйл ажиллагааны мэдээ мэдээллийг <https://darkhan-uul.burtgel.gov.mn/>, Дархан-Уул Улсын бүртгэлийн хэлтэс, Дархан-Уул аймаг фэйж хуудас, Дархан хамгийн том зарын грүүп зэрэг цахим хуудаст тогтмол байршуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд хэлтсийн пэйж хуудсанд 85-н мэдээ, мэдээлэл фэйсбүүк хуудас 512 мэдээллийг байршуулж 35000 гаруй иргэнд мэдээллийг хүргэн ажилласан.

Дархан-Уул Улсын бүртгэлийн хэлтэс фэйсбүүк хуудас 618, Дархан-уул аймаг дахь пейж хуудас 2122-н дагагчтай байна.





2. Үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангах зорилгоор үйлчилгээний танхимд албан хаагчид, удирдлагуудын утасны жагсаалт, санал хүсэлтийн дэвтэр, ажлын цагийн хуваарийг шинэчлэн ил тод нээлттэй байршуулсан.




3. Бүртгэлийн үйлчилгээ авахад шаардагдах гарын авлага, бүрдүүлэх материалыг жагсаалтыг шинэчлэн үйлчилгээний зааланд байршуулан ажиллаж байна.




4. Иргэдийн санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэх, мэдээ мэдээллийг орон зай цаг хугацаанаас үл хамааран хүргэх зорилгоор нээлттэй утас 70373944, нэмэлтээр 70373604 дугаарыг ажиллуулж тайлант хугацаанд 313 иргэнд зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан.



**Улсын бүртгэлийн хэлтсийн САНАЛ ХҮСЭЛТ  
ХҮЛЭЭН АВАХ ЦАХИМ ШУУДАН, НЭЭЛТТЭЙ  
УТАС**

 [Darkhanuul@burtgel.gov.mn](mailto:Darkhanuul@burtgel.gov.mn)

 **7037-3944**

5. Иргэдэд мэдээлэл сурталчилгааг ил тод нээлттэй хүргэх зорилгоор хэлтсийн байрны гадна талбайд мэдээлэлийн самбарыг шинээр байршуулж үйл ажиллагааг сурталчлан ажиллаж байна. Мөн цагийн хувиарыг хэлтсийн гадна хананд давхар байршуулсан.



6. Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулсан мэдээлж байх ажлын хүрээнд санхүү болон хүний нөөцийн ил тод байдлын самбарын мэдээллийг тухай бүр мэдээллээ шинэчилэн байршуулан ажиллаж байна. Мэдээллийн самбарт 2021 оны Улсын бүртгэлийн ерөнхий газраас авч хэрэгжүүлж байгаа төлөвлөгөөний дагуу төрийн үйлчилгээ авахтай холбоотой улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж буй хаяг байршил, бичиг баримтын бүрдүүлэлт, үйлчилгээний үнэ хураамжийн талаарх мэдээл агуулсан самбарыг холбогдох үйлчилгээний байранд байршуулж иргэдийг мэдээллээр ханган ажиллаж байна.



### **АРВАН ЗУРГАА: ШИНЭЛЭГ АЖЛУУД:**

1. Дархан-Уул аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхээс ирүүлсэн 2021 оноос өмнөх шийдвэрүүдийн дагуу иргэд гэрлэлт дуусгавар болсноо бүртгүүлсэн эсэхийг мэдээллийн санд шалгаж бүртгүүлээгүй иргэдтэй холбогдож мэдээлэл зөвлөгөөг өгч ажилласан. Энэ ажлын хүрээнд тайлангийн хугацаанд 2021 оноос өмнө шүүхийн шийдвэрээр гэрлэлт нь дуусгавар болсон **48-н** иргэний бүртгэлийг хөтөлж, өөр аймаг, нийслэлд оршин суугаа **7-н** иргэнд харьяалал харгалзахгүй бүртгүүлэх боломжтойг зөвлөн бүртгэлд хамруулсан.

2. Аймгийн хэмжээнд 4 дүгээр сарын 10-ны өдрөөс 5 дугаар сарын 08-ны өдрийг хүртэл хугацаанд хатуу хөл хорио тогтоосонтой холбогдуулан тус хэлтсээс анх удаа болон 25, 45 насны сунгалтын бүртгэл хийлгэсэн, гэж үрэгдүүлэн дахин захиалсан **468-н** иргэний үнэмлэхийг халдвар хамгааллын дэглэмийг сахин иргэдэд гэрийн хаягаар нь хүргэх ажлыг зохион байгуулан ажилласан.



3. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын үүрэг чиглэлийн дагуу хэлтсийн үйлчилгээний зааланд “**ЦАХИМ БУЛАН**” –г бий болгон иргэд цахимаар бүртгэлийн үйлчилгээг авах нөхцөлийг бүрдүүлэн ажилласан.



4. Бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, хүртээмжтэй, нээлттэй хүргэх зорилгоор **ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД** тусгайлан зориулан Улсын бүртгэлийн ерөнхий хууль, иргэний улсын бүртгэлийн бүртгэлд бүртгүүлэхэд

бүрдүүлэх 14-н төрлийн үйлчилгээний мэдээллийг **“БРАЙЛ КРИЛЛ ҮСЭГ ХОСОЛСОН ГАРЫН АВЛАГА”** болгон гаргаж аймгийнхаа “Харааны бэрхшээлтэй иргэдийн холбоо” -нд хүлээлгэн өгч мөн үйлчилгээний зааландаа байршуулан , Хараагүйчүүдийн холбооны гишүүн И.Мөнхшүр нь жил бүрийн 10 сард зохион байгуулагддаг **“Цагаан таягтны өдөр”**-өөр харааны бэрхшээлтэй иргэддээ уг мэдээллийг илүү өргөн хүрээнд хүргэх бөгөөд төрийн үйлчилгээний байгууллагуудаас анх удаа ийм сайхан ажлыг санаачлан цаг хугацаа, орон зайнаас үл шалтгаалан хэн нэгний тусламжгүйгээр улсын бүртгэлийн мэдээллийг авах боломжийг бүрдүүлэн ажилласан.



5. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 2-10/996 тоот албан бичгээр ирүүлсэн **“Ёс зүйтэй, хүнд сурталгүй, төрийн алба”** аяныг зохион байгуулах чиглэлийн дагуу албан хаагчдаас гаргасан санал санаачлагыг дэмжин үйлчилгээний зааланд байрлах цонх тус бүрд Санал хүсэлтийн дэвтрийг байршуулж дэвтэрт иргэдэд ойлгомжтой байдлаар тухайн албан хаагчийн хариуцсан ажил, утасны дугаар, нэр, зураг зэргийг тодорхой харагдах байдлаар шинэчлэн бичиж байршууллаа. Мөн үйлчилгээний зааланд үйлчилгээ үзүүлж буй албан хаагчдын нэр, ажлын чиг үүрэг, хариуцсан удирдах албан тушаалтны утасны дугаарыг ил тод нээлттэй байршуулсан бөгөөд тус тасгийн 5-н улсын бүртгэгчийн санал, хүсэлтийн дэвтэрт 155-н иргэн санал хүсэлтээ бичиж үлдээснийг үзэхэд: **151-н** талархал, **4** нь бүртгэлийн орчин нөхцөлийг сайжруулах талаар санал тэмдэглэсэн байна.





Архивын чиглэлээр:

7. Иргэний баримтын архивын хадгаламжийн нэгж болох хувийн хэргийг тоолж цэгцлэх, ажлын тусгайлсан төлөвлөгөө гарган хэлтсийн даргаар батлуулан хувийн хэргийг нэг бүрчлэн мэдээллийн сантай тулган шалгаж хувийн хэргийн галиглан тухайн хайрцагт буруу байрлуулсан, өөр аймаг, нийслэлийн харьяат иргэний хувийн хэргийг ялгаж тоолох ажлыг хийж гүйцэтгэх ажлыг 1 дүгээр улирлаас эхлүүлэн архивт хадгалагдаж буй нийт **313 хайрцаг** /нас баралт, төрөлтөөс бусад/ хувийн хэргээс **313 хайрцаг** хувийн хэргийг шалгаж тоолон цэгцэлж шалган Нийслэл дэх улсын бүртгэлийн газарт 5590, өөр аймагт 1844 нийт **7.434** ширхэг хувийн хэргийг холбогдох газарт хүргүүлсэн бөгөөд ажлын явц 100 хувийн гүйцэтгэлтэй байна.



8. **Эрдэм шинжилгээний лавлах:** Баримтын агуулга бүрэлдэхүүн, байршлын талаар хоёрдогч мэдээллийг өөртөө агуулсан хоорондоо харилцан уялдаа холбоо бүхий баримтын мэдээллийг эрж хайх, ашиглах үйл ажиллагааг хөнгөн шуурхай болгох зорилготойгоор эрдэм шинжилгээний лавлах мэдээллийн санг хийсэн.




9. Тайлангийн хугацаанд байгууллагын архивт байнга хадгалах архивын хадгаламжийн нэгжийн удирдлагын баримтын 2016-2020 оны нийт 20 архивын хадгаламжийн нэгжийн **600 хуудас** баримт бичгийг скайнердан **цахим архив үүсгэсэн** бөгөөд архивын баримтыг түргэн шуурхай ашиглах боломж бүрдсэн.

10. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын эх нотлох баримтыг цахим мэдээллийн сантай тулгаж тоолох ажлыг **21 аймгийн хэмжээнд анх удаа** санаачилж эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн улсын бүртгэгч нар архивч

хяналтын улсын байцаагч нарын бүрэлдэхүүнтэй тооллогын комиссыг хэлтсийн даргын 2021 оны 01 дүгээр сарын 08-ны А/03 дугаартай тушаалаар батлуулж хуваарийн дагуу үл хөдлөх эд хөрөнгийн 5000 хувийн хэрэг тоолсноос өмчлөгчийн мэдээлэл буруу, дутуу нотлох баримт дутуу цахимжсан 406-н зөрчлийг илрүүлж хяналтын улсын байцаагчаар дүгнэлт гаргуулан 100% залруулж ажилласан.

11. Данс бүртгэл: Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт хадгалагдаж буй Үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 23861-н хувийн хэрэгт, Хонгор сумын газар өмчлөх, эрхийн улсын бүртгэлийн Г200400001-2004001017 хувийн хэргийн тоо бүртгэлжүүлэн дансжуулах ажлыг 100% хийж гүйцэтгэсэн.



БАТЛАВ  
БНШЗСК-ЫН 2021 ОНЫ 01 ДУГААР  
САРЫН 08-НЫ ОДРИЙН 03 ДУГААР  
ХУРИЛЫН ТЭМДЭГЛЭЛ

УЕХ-ИЙН ДАРГЫН ҮЙСЭГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  
2021 он 08 сар 15 өдөр

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС  
ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАРХАН СУМЫН  
ГАЗАР ӨМЧЛӨХ ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН  
ХАДГАЛАМЖИЙН НӨРӨЛЖИЙН БҮРТГЭЛ  
2004.2021он

А/А	Хувийн хэрг дугаар	Байгаа байхгүй эсэх / х - / тавих	Хуудасны тоо	Тайлбар
1	XHG200500001	байна	1-28 хуудас	2021.06.07
2	XHG200500002	байна	1-09 хуудас	2021.06.07
3	XHG200500003	байна	1-42 хуудас	2021.06.07
4	XHG200500004	байна	1-63 хуудас	2021.06.07
5	XHG200500005	байна	1-78 хуудас	2021.06.07
6	XHG200500006	байна	1-37 хуудас	2021.06.07
7	XHG200500007	байна	1-21 хуудас	2021.06.07
8	XHG200500008	байна	1-16 хуудас	2021.06.07
9	XHG200500009	байна	1-28 хуудас	2021.06.07
10	XHG200500010	байна	1-19 хуудас	2021.06.07
11	XHG200500011	байна	1-23 хуудас	2021.06.07
12	XHG200500012	байна	1-45 хуудас	2021.06.07
13	XHG200500013	байна	1-47 хуудас	2021.06.07
14	XHG200500014	байна	1-28 хуудас	2021.06.07
15	XHG200500015	байна	1-18 хуудас	2021.06.07
16	XHG200500016	байна	1-20 хуудас	2021.06.07
17	XHG200500017	байна	1-18 хуудас	2021.06.07
18	XHG200500018	байна	1-16 хуудас	2021.06.07
19	XHG200500019	байна	1-19 хуудас	2021.06.07
20	XHG200500020	байна	1-13 хуудас	2021.06.07
21	XHG200500021	байна	1-17 хуудас	2021.06.07
22	XHG200500022	байна	1-41 хуудас	2021.06.07
23	XHG200500023	байна	1-89 хуудас	2021.06.07
24	XHG200500024	байна	1-183 хуудас	2021.06.07
25	XHG200500025	байна	1-28 хуудас	2021.06.07
26	XHG200500026	байна	1-11 хуудас	2021.06.07
27	XHG200500027	байна	1-170 хуудас	2021.06.07
28	XHG200500028	байна	1-42 хуудас	2021.06.07
29	XHG200500029	байна	1-20 хуудас	2021.06.07
30	XHG200500030	байна	1-12 хуудас	2021.06.07

БАТЛАВ  
УЕХ-ИЙН ДАРГЫН ҮЙСЭГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  
2021 он 08 сар 15 өдөр


УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС  
ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАРХАН СУМЫН ҮЛ ХӨДЛӨХ БОЛОН  
ГАЗАР ӨМЧЛӨХ ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН  
ДУГААРЫН БҮРТГЭЛ  
1997-2020он

А/А	Дугаар олголтын дэврийн дугаар	Он сар өдөр	Дэврийн дугаар 1-3	Тайлбар
1	У-200300001-2003004384	1997-1998		
2	У-2003004354-2003007146	1999-2000	4	
3	У-2003007199-2003010781	2000-2002	5	
4	У-20030010742-2003013820	2001-2006	6	
5	У-20030013821-2003014470	2010-2011	7	
6	У-2003014741-2003015240	2011	8	
7	У-2003015241-2003015730	2011	9	
8	У-2003015731-2003016170	2012-2013	10	
9	У-2003016170-2003016572	2013	11	
10	У-2003020090-2003020774	2016	12	
11	У-2003020306-2003021287	2016	13	
12	У-2003020775-2003021243	2017	14	
13	У-2003021244-2003021652	2018	15	
14	У-2003021288-2003022269	2019	16	
15	У-2003022270-2003023073	2020	17	

2014-2015 он байхгүй байна /Бат-Эрдэнэ/

12. <http://burtgel.smartdarkhan.com/> цахим хуудсыг ажиллуулж эхэлсэн бөгөөд Иргэний үнэмлэх, гадаад паспорт захиалсан иргэд бүртгэлийн байгууллагад өөрийн биеэр ирэхгүйгээр цахим хуудаст хандан өөрийн регистрийн дугаараа

оруулан цахим үнэмлэх, гадаад паспортыг хэвлэгдэн ирсэн эсэхийг мэдэх боломжтой болсон.



13. **CallPro** үйлчилгээг нэвтрүүлсэн. 7037-1212 дугаарт залган 2 товчийг дарснаар Улсын бүртгэлтэй холбоотой 3-н төрлийн үйлчилгээг авахад шаардлагатай материал мэдээллийг автомат хариулагчаас авах боломжтой болсон. Үүнд:

- Үл хөдлөх эд хөрөнгө өмчилдөг эсэх лавлагаа
- Өөрийн өмчлөлийн газар дээр хувийн сууц, грааш, дэлгүүрийн зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ
- Гэрээ хэлцлийн үндсэн дээр үл хөдлөх эд хөрөнгө өөр этгээдэд шилжих



14. Байгууллагын гадна болон өрөө тасалгаа, үйлчилгээний цонхны хаягуудыг “**ХОС БИЧИГ**”-ээр бичиж шинэчлэв.






15. Хэлтсийн үйлчилгээг сайжруулах албан хаагчдын ур чадвар, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор хэлтсийн даргын 2021 оны 10 дугаар сарын А/17 дугаар тушаалаар баталсан “Сэтгэл ханамжийн судалгаа”-г цахим болон цаасан хэлбэрээр авсан.

Судалгаанд нийт 231 иргэн хамрагдснаас 51 хувь нь бүртгэлийн үйлчилгээг авахад хүндрэл, асуудал байхгүй, 19 хувь нь хууль тогтоомж дүрэм журам ойлгомжгүй, 13 хувь нь үйлчилгээний төлбөр тооцоог гэрэгэ системээр төлөхөд хүндрэлтэй, 11 хувь нь албан хаагчдын харилцаа хандлага ур чадвар тааруу, бусад-6 хувьтай хариулт өгсөн байна.





## АРВАН ДОЛОО: БУСАД

1. Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Нэг өрх-Нэг шинжилгээ” аяны хүрээнд иргэдийг PSR шинжилгээнд хамруулах ажлын хүрээнд Дархан сумын 3 дугаар багийн нийт өрхийг хамруулах ажлыг хэлтсийн албан хаагчид хамтран амжилттай зохион байгуулсан.



2. Бүх нийтийн хөл хорионы үеэр Аймгийн Онцгой комиссоос гаргасан шийдвэр, хуваарийн дагуу “Эргүүл”-ийн ажлыг хийж гүйцэтгэсэн.



3. Ковид 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд иргэдийг Вакцины 1, 2 дугаар тунд хамруулах ажлын хэсэгт орж нийтдээ 1,2 дугаар тундаа хамрагдсан давхардсан тоогоор 3000 гаруй иргэдийг вакцинжуулах ажлыг өрхийн эмнэлгийн эмч, сувилагч нартай хамтран хийж гүйцэтгэсэн.



4. Тус хэлтсийн албан хаагчдын санаачилгаар ковид-19 цар тахлын үед нэн шаардлагатай 1.000,000/нэг сая/ төгрөгийн үнэ бүхий амьсгалын аппаратыг тус аймгийн Орхон сумын эмнэлэгт хандивлаж улсын бүртгэгч С.Сүхбаатар нь хамт олноо төлөөлөн гардуулж өгсөн.




5. Дархан хотын түүхт 60 жилийн ойн угтаж хэлтсийн байрны гадна талд тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн.






Байгууллагын эцэг эхийн зөвлөлийн ажлын хүрээнд:

9. Ковид-19 цар тахал гарсантай холбоотой хөл хорио тогтоосон үед “Хариуцлагатай эцэг эхчүүд” уриан дор хүүхэдтэйгээ ном унших аяныг хэлтсийн хэмжээнд зохион байгуулж уншсан номын талаар ярилцсан бичлэгийг хамт олны цахим хуудсанд байршуулсан.



10. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан “Миний аав, ээж ажил дээрээ” сэдэвт гар зургийн уралдааныг албан хаагчдын хүүхдүүдийн дунд цахимаар зохион байгуулан шалгарсан зургийн хүүхдүүдийг урамшуулсан.

Мөн албан хаагчдын 0-16 насны 45 хүүхдэд баярын бэлгийг гардуулан өгсөн.








11. Олон улсын гэр бүлийн өдрийг угтан “Миний сэтгэлийн үгс “ сэдэвт чин сэтгэлийн захидлыг эцэг эхчүүд бичиж хүү /охин/-доо илгээсэн.



12. 2021-2022 оны хичээлийн шинэ жилд хэлтсийн хэмжээнд 1 дүгээр ангид анх элсэн орж буй бяцхан 2 охинд гарын бэлэг, дурсамж хадгалуулав.



13. Авилгатай тэмцэх газраас зарласан Зөвд зөв, шударга зөв соён гэгээрүүлэх ажлын хүрээнд тус хэлтсийн Эцэг эхийн зөвлөлөөс санаачлан албан хаагчдын хүүхдүүдийн дунд “ШУДАРГА ЁС ” сэдэвт эссэ,зохион бичлэгийн уралдаан зарлаж амжилттай оролцсон хүүхдүүдийг урамшуулан ажиллалаа.



**АРВАН НАЙМ: ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ:**

Тус хэлтэс нь бүртгэлийн үйл ажиллагааг хэвийн явуулж иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангаж ажиллахад тулгамдаж буй асуудлууд :

1. АЗДТГ-ын хамгаалалтын ажилтан хэлтсийн байрны харуул хамгаалалтын ажлыг давхар хариуцан ажиллаж байгаа нь ажлын байрны аюулгүй байдалд эрсдэл үүсэх магадлалтай тул орон тоог бий болгох.
2. Бичиг хэргийн ажилтан нь няравын ажлыг давхар хариуцаж байгаа нь ажлын ачааллыг нэмэгдүүлж байгаа тул орон тоог нэмэх.
3. Хэлтсийн гэрээт /үйлчлэгч, жолооч/ ажилтныг төрийн үйлчилгээний албан хаагчийн ангилалд хамааруулах. /Цалингийн хэмжээ бага тул ажиллах хүчин хомс/

4. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны, гамшгаас хамгаалах эрсдлийг бууруулах арга хэмжээний зардлууд огт тусгагдаагүй, сургалт, бичиг хэргийн болон шатахууны зардал хүрэлцдэггүй асуудлыг шийдвэрлэх.

ХЯНАСАН:

ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

М.ХУВЬЗАЯА

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

НЯРАВ, БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ

Э.БУРМАА